



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**ХАЛАМЖИЙН САНГИЙН ДИЙЛЭНХ НЬ АМЬЖИРГАА ХАРГАЛЗАХГҮЙ
ОЛГОДОГ НИЙТЛЭГ МӨНГӨН ТЭТГЭМЖИД ЗАРЦУУЛАГДАЖ БАЙНА**

**АУДИТЫН СЭДЭВ: ТӨРӨӨС НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ
БОДЛОГО, СТРАТЕГИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ, ТҮҮНИЙ ҮР НӨЛӨӨ**

АУДИТЫН КОД: ГНАГ-2023/16-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх
аудитор Д.Энхболд

Утас: 263755, Цахим хаяг: enkhboldd@audit.gov.mn

Аудитын менежер Х.Баярмаа

Утас: 261639, Цахим хаяг: bayarmaakh@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Сандуйжав

Цахим хаяг: sanduijavb@audit.gov.mn

З.Мөнхбаяр

Цахим хаяг: munkhbayarz@audit.gov.mn

Аудитор Ш.Наранбаатар

Цахим хаяг: naranbaatarsh@audit.gov.mn

М.Сангижанцан

Цахим хаяг: sangijantsanm@audit.gov.mn

Э.Уужимсан

Цахим хаяг: uujimsane@audit.gov.mn

Улаанбаатар хот

2023 он

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	2
Хүснэгтийн жагсаалт	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл	4
БҮЛЭГ 1: Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн зарим үйл ажиллагааны үр дүнг хэрхэн тооцох талаар тодорхой төлөвлөөгүй байна. .6	6
Бодлогын зарим баримт бичгүүдийн зорилго, зорилт хэмжигдэхүйц бус тусгагдсан, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй байна	6
Бодлогын баримт бичигт тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн хөтөлбөргүй, зарим үйл ажиллагааны санхүүжилтийг бодитой төлөвлөөгүй байна.....	11
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүжилтийн хэмжээ тодорхойгүй байна.....	11
БҮЛЭГ 2: Нийгмийн халамжийн талаарх хууль, эрх зүйн шинэчлэл бүрэн хийгдээгүйгээс зарим арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.....	13
Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан нийгмийн халамжийн талаар авч хэрэгжүүлсэн нийт 14 арга хэмжээний 2 нь үр дүнд хүрсэн, 6 нь тодорхой үр дүнд хүрсэн, 6 арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байна.	13
Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийгмийн халамжийн талаар тусгагдсан зарим зорилт арга хэмжээ бүрэн хэрэгжсэн ч шалгуур үзүүлэлтэд заасан хүрэх түвшиндээ ядуурлын түвшин, ажиллах хүчний оролцооны түвшин хүрэхгүй байх эрсдэлтэй байна.....	23
Нийгмийн халамжийн салбарын стратеги төлөвлөгөөнд тусгасан зорилт хуулийн шинэчлэл хийх зарим арга хэмжээ хэрэгжээгүйтэй холбоотойгоор бүрэн хэрэгжээгүй байна.....	25
БҮЛЭГ 3. Халамжийн сангийн хөрөнгийг зорилтод бүлгээс илүү нийтийг хамарсан шинжтэй үйлчилгээнд зарцуулж байна	31
“Нийгмийн халамж” гэж тодорхойлсон үйл ажиллагаанд нийцээгүй, нийтийг хамарсан шинжтэй үйлчилгээнд халамжийн сангийн 80 орчим хувийг зарцуулж байна.	31
ДҮГНЭЛТ	41
ЗӨВЛӨМЖ.....	42
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ.....	43
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР	53

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

Товчилсон үгийн тайлбар

МУ	Монгол Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ХБТТУТХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
ЭЗОХӨТЭЭТОТХ	Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль
УИХ	Улсын Их Хурал
ГНАГ	Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
ШТА	Шууд тайлагнах ажил
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗГ	Засгийн газар
МУЗГҮАХ	Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ХНХ	Хөдөлмөр, нийгмийн хамгаалал
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ЭЗХЯ	Эдийн засгийн хөгжлийн яам
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ЦХХХЯ	Цахим хөгжил, харилцаа холбооны яам
БХЯ	Батлан хамгаалахын яам
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ГХЯ	Гадаад харилцааны яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
СЯ	Сангийн яам
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ЭХЯ	Эрчим хүчний яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
УТ	Улсын төсөв
ГЗТ	Гадаадын зээл тусламж
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Бодлогын баримт бичгүүдэд тусгасан нийгмийн халамжийн талаарх арга хэмжээний зорилго, зорилт	6
Хүснэгт 2	НҮБ-ын тогтвортой хөгжил зорилго 2030-д тусгасан арга хэмжээний зорилт	8
Хүснэгт 3	Хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн уялдаа	8
Хүснэгт 4	Шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтод түвшнийг тодорхойлсон байдал	9
Хүснэгт 5	Стратеги төлөвлөгөөнд туссан нийгмийн халамжийн чиглэлээрх зорилт	11
Хүснэгт 6	Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан нийгмийн халамжийн талаар авч хэрэгжүүлсэн зорилтуудын үр дүнгийн үнэлгээний нэгтгэл	13
Хүснэгт 7	Нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тогтоолд орсон өөрчлөлтүүд	14
Хүснэгт 8	Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийгмийн халамжийн талаар тусгагдсан шалгуур үзүүлэлтийн үр дүн	24
Хүснэгт 9	Халамжийн сангийн зарцуулалт	33
Хүснэгт 10	Халамжийн сангийн зарцуулалт	35
Хүснэгт 11	Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн зарцуулалт	35
Хүснэгт 12	Нийгмийн халамж авагч иргэдийн нийт хүн амд эзлэх хувь	36
Хүснэгт 13	Нэг иргэний авсан үйлчилгээний тоо	36
Хүснэгт 14	Иргэдийн үйлчилгээ авч буй хэлбэр	37
Хүснэгт 15	Нийгмийн даатгалд бүртгэлтэй иргэдийн хамгийн их авсан нийгмийн халамжийн үйлчилгээ	38
Хүснэгт 16	Нийгмийн халамжийн хэмжээ ядуурлын шугамын харьцаа	39
Хүснэгт 17	Нийгмийн халамжийн хэмжээ өрхийн амьжиргааны түвшний харьцаа	39

Дүрслэлийн жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн схем	6
Дүрслэл 2	Нийгмийн халамжийн үйлчилгээ “Нийгмийн халамж” тодорхойлолтод нийцсэн байдал	32

Хавсралтын жагсаалт

Дугаар	Агуулга
Хавсралт 1	Хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн уялдаа
Хавсралт 2	Хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтод түвшнийг тодорхойлсон байдал
Хавсралт 3	Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөнд туссан нийгмийн халамжийн чиглэлийн стратеги, үзүүлэлтүүд
Хавсралт 4	Нийгмийн халамжийн үйлчилгээ “Нийгмийн халамж” тодорхойлолтод нийцсэн байдал
Хавсралт 5	Халамжийн сангийн зарцуулалт

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны 09 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/04 дүгээр тушаалыг үндэслэн “Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудит хийлээ.

Аудитын зорилго

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөөнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Нийгмийн халамжийн бодлого, стратегийн үр дүнг тооцох боломжтой байдлаар төлөвлөсөн эсэх;
- Нийгмийн халамжийн бодлого, стратегийн хэрэгжилт үр нөлөөтэй эсэх

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон холбогдох бусад байгууллагыг хамруулан нийгмийн халамжийн чиглэлээрх бодлогын баримт бичгүүд, хэрэгжүүлсэн арга хэмжээний төлөвлөгөө, тайлан, хяналт, үнэлгээ, нийгмийн халамжийн сангийн баримт материалууд, нийгмийн халамж авагч иргэдийн мэдээллийн хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Мөн Нийгмийн даатгалын ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Үндэсний статистикийн хороо зэрэг байгууллагуудаас аудитын сэдэвт хамаарах мэдээллийн хамрууллаа.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах зэрэг аудитын арга зүйг ашиглан гүйцэтгэж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашигласан. Үүнд:

- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Нийгмийн халамжийн тухай хууль,
- Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хууль,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль,
- Ахмад настны тухай хууль,
- Эх, эцэг олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль,
- Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хууль,
- “Монгол Улсын Их Хурлын 2010 оны 54 дүгээр тогтоол “Мөнгөн тусламжийн хэмжээг өөрчлөн тогтоох тухай”,

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого,
- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”,
- Монгол Улсын Их Хурлын 2022 оны 71 дүгээр тогтоол “Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн талаар авах арга хэмжээний тухай”,
- Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 194 дүгээр тогтоол “Нийгмийн халамжид хамрагдах иргэний хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авах, шийдвэрлэх журам батлах тухай”,
- Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 2 дугаар тогтоол “Журам батлах тухай” /Өрхийн мэдээллийн нэгдсэн санг удирдах, ашиглах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журам/,
- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 199 дүгээр тогтоол “Журам батлах тухай” /Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай/,
- Холбогдох бусад хууль, эрх зүйн актууд,
- Хүн амын амьжиргаа түвшин, ядуурал, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой болон бусад үзүүлэлтүүд,
- Халамжийн үйлчилгээний чиглэлээр хийсэн судалгаа, шинжилгээний тайлан, материалууд.

Аудитын багийн бүрэлдэхүүн

Аудитыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд удирдаж, аудитын менежер Х.Баярмаа үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Сандуйжав, З.Мөнхбаяр, аудитор Ш.Наранбаатар, М.Сангиганцан, Э.Уужимсан нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Мөн аудитад Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын ахлах аудитор Б.Мөнхцэцэг, Мэдээллийн технологийн төвийн программ хөгжүүлэгч шинжээч А.Чойжин нар нийгмийн халамж авагч иргэдийн мэдээлэлд дүн шинжилгээ, тулган баталгаажуулалт хийсэн бөгөөд үр дүнг аудитын тайланд ашиглалаа.

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

БҮЛЭГ 1: Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн зарим үйл ажиллагааны үр дүнг хэрхэн тооцох талаар тодорхой төлөвлөөгүй байна.

Бодлогын зарим баримт бичгүүдийн зорилго, зорилт хэмжигдэхүйц бус тусгагдсан, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй байна

1.1. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд урт, дунд, богино хугацааны баримт бичгүүд харилцан уялдаатай, бодлогын зорилт, суурь түвшин, шалгуур үзүүлэлт, зорилтод түвшнийг тодорхойлохоор тусгасан байна. Бодлогын зорилт нь бодлогын зорилгод нийцсэн, улс, салбар, салбар хооронд болон бүс орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн уялдааг хангасан тодорхой, хэмжигдэхүйц, хүрч болохуйц, хэрэгжихүйц, бодитой, хугацаатай эерэг өөрчлөлтийг гэж заасан байна.

Дүрслэл 1. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн схем



Эх сурвалж: ХБТТУТХ

1.2. Монгол Улсын урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгасан нийгмийн халамжийн талаарх арга хэмжээ нь ХБТТУТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.2.12¹-т заасан төлөвлөлтийн дээрээс доош, доороос дээш чиглэх тэнцвэрт байдлыг хангах зарчимтай нийцээгүй байна.

1.3. Бодлогын баримт бичгүүдэд тусгасан нийгмийн халамжийн талаарх арга хэмжээний зорилго, зорилтыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

Хүснэгт 1: Бодлогын баримт бичгүүдэд тусгасан нийгмийн халамжийн талаарх арга хэмжээний зорилго, зорилт

№	Бодлогын баримт бичгүүд	Зорилго	Зорилт
1	Алсын хараа-2050	Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин өрхийн орлогыг тогтвортой нэмэгдүүлж, идэвхтэй бүтээлч гэр бүлийг төлөвшүүлэн, хэрэгцээндээ нийцсэн байр сууц бүхий, хөрөнгө оруулалтын таатай	Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжиж идэвхтэй, бүтээлч иргэн, гэр бүлийг төлөвшүүлнэ.

¹"төлөвлөлтийн дээрээс доош, доороос дээш чиглэх тэнцвэрийг хангах зарчим" гэж "дээрээс доош төлөвлөх буюу нэгдсэн зорилго, зорилтыг дэвшүүлж салбар болон бүс нутгуудад хэрэгжүүлэх, "доороос дээш" төлөвлөх буюу төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрүүдийн саналыг нэгтгэн, нэгдмэл зорилго, зорилтыг тодорхойлж төлөвлөхийг;

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

		орчин, нөхцөлд өрсөлдөхүйц бичил, жижиг, дунд бизнес эрхлэн өрх, гэр бүл, өөрийгөө тэтгэн амьдрах боломжтой, сэтгэл хангалуун амьдрах нөхцөлөөр тэтгэгдсэн дундаж давхаргыг бүрдүүлнэ.	
		Чанартай амьдралын баталгаа бүхий нийгмийн хамгаалалтай, аз жаргалтай амьдралын ээлтэй орчинд, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн нийгмийн идэвхтэй, эрүүл монгол хүнийг хөгжүүлнэ.	Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ.
2	МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, хүн амыг орон сууцаар хангах тогтолцоог бий болгож, дундаж давхаргын хүрээг тэлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ.	Нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчилнэ.
3	МУЗГҮАХ 2020-2024	Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ.	Өрхийн амьжиргааны түвшнийг тогтоох аргачлалыг боловсронгуй болгож, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг тууштай бууруулна.
4	МУ-ын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө	Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ.	“Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй болгоно.
5	МУ-ын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө	Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ажиллах хүч бэлтгэж, ажлын байрыг нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, нийгмийн хамгааллыг зорилтот бүлэгт чиглүүлж, халамжаас хөдөлмөрт шилжих оновчтой бодлого хэрэгжүүлнэ.	Орлого багатай өрхийн ажил эрхлэхгүй байгаа насанд хүрсэн гишүүдийг мэргэшил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

Эх сурвалж: МУ-ын хөгжлийн бодлогын баримт бичгүүд

1.4. Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн зорилго, зорилтуудыг ялгаж ангилаагүй, харилцан уялдаагүй, нэгдмэл бус байна. Тодруулбал: Хөгжлийн бодлогын зорилтод нийгмийн халамжийн асуудлаар хангалттай тусгагдаагүй, зорилтууд нь зорилгодоо хүрэх эсэх нь тодорхойгүй, оновчтой бус, олон төрлийн зорилгуудыг багтаасан, хүрч болохуйц байдал нь учир дутагдалтай байна. Энэ нь ХБТТУТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.16², мөн 4.1.17³-д заасантай нийцэхгүй байна.

² "Бодлогын зорилго" гэж улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн уялдааг хангасан, хүрч болохуйц эерэг өөрчлөлтийг;"

³ "Бодлогын зорилт" гэж бодлогын зорилгод нийцсэн, улс, салбар, салбар хооронд болон бүс орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн уялдааг хангасан тодорхой, хэмжигдэхүйц, хүрч болохуйц, хэрэгжихүйц, бодитой, хугацаатай эерэг өөрчлөлтийг;

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

1.5. НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилго 2030-ын хүрээнд ядуурал, тэгш бус байдлыг бууруулах, эдийн засгийн өсөлт, зохистой хөдөлмөрийг дэмжих зорилтуудыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

Хүснэгт 2: НҮБ-ын тогтвортой хөгжил зорилго 2030-д тусгасан арга хэмжээний зорилт

№	Зорилтууд
1	Санхүү, цалин, нийгэм хамгааллын бодлогыг батлан хэрэгжүүлж, тэгш байдлыг аажмаар хангах.
2	Бага орлоготой хүн амын 40 хувийн орлогын өсөлтийг үндэсний дунджаас дээгүүр түвшинд аажмаар хүргэж, хадгалах.
3	Өдөрт 1.25 ам.доллараос бага орлоготой гэж одоогоор тооцогдож буй хүмүүсийн туйлын ядуурлыг арилгах
4	Үндэсний тодорхойлолтын дагуу ядуурлын бүх хэмжигдэхүүнээр ядуу амьдарч байгаа бүх насны эрэгтэй, эмэгтэй, хүүхдийн хувийн жинг наад зах нь хоёр дахин бууруулах.
5	Үндэсний онцлогт тохирсон нийгэм хамгааллын тогтолцоо, бүх хүнд зориулсан нийгэм хамгааллын арга хэмжээ, түүний дотор нийгэм хамгааллын үндсэн үйлчилгээг нэвтрүүлж, түүнд ядуу, эмзэг бүлгийн дийлэнх хэсгийг 2030 он гэхэд хамруулах.
6	Эрэгтэй, эмэгтэй хүн бүр, ялангуяа ядуу, эмзэг бүлгийнхэн эдийн засгийн нөөц бололцоог эрх тэгш авч ашиглах, түүнчлэн нийгмийн үндсэн үйлчилгээ, газар болон бусад хэлбэрийн эд хөрөнгө өмчлөх, захиран зарцуулах, өв залгамжлах, байгалийн баялаг, зохих шинэ технологи, санхүүгийн үйлчилгээ, түүний дотор бичил санхүүгийн үйлчилгээнд хамрагдах боломжийг бүрдүүлэх.
7	Ядуурлын бүх хэлбэрийн арилгах бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор хөгжиж буй орнууд, ялангуяа хөгжиж буй орнуудад хүртээмжтэй, урьдаас тодорхой арга хэрэгслээр хангах үүднээс хөгжлийн хамтын ажиллагааг сайжруулах замаар төрөл бүрийн эх үүсвэрээс хөрөнгө мөнгийг үлэмж хэмжээгээр бүрдүүлэх.

Эх сурвалж: НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилго 2030 баримт бичиг

1.6. Дээрх байдлаас харахад тогтвортой хөгжлийн зорилтуудыг олон төрлийн арга хэмжээ нэг дор хэрэгжүүлэхээр тусгаагүй буюу нэг асуудалд чиглэсэн, хэмжиж болохуйц, тодорхой хугацаанд хүрч болохуйц байдлаар илэрхийлсэн байна.

1.7. Иймд бодлогын баримт бичгүүдийн зорилго, зорилтыг тодорхой, үр дүнг хэмжиж болохуйц байдлаар ХБТТУТХ-д нийцүүлэх шаардлагатай байна.

1.8. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх арга хэмжээг дунд, богино хугацааны бодлогын баримт бичиг, салбарын стратеги төлөвлөгөөтэй харьцуулан харуулбал:

Хүснэгт 3: Хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн уялдаа

№	МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	МУ-ын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө	МУ-ын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө	ХНХ-ын салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө	Санхүүжилт /2021-2024/ /сая.төгрөг/
Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо						
1	Өрхийн амьжиргааны түвшнийг тогтоох аргачлалыг боловсронгуй болгож, гэр бүлийн гишүүн бүрд үзүүлэх нийгмийн халамжийн тусламж, дэмжлэгийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.					
	-	2	1	-	-	8,900.0 /УТ/
2	Өрхийн хүнсний баталгаат байдал алдагдахаас зорилтот, эмзэг бүлгийн хүн амыг хамгаалах нийгмийн хамгааллын арга хэмжээг бэхжүүлэх.					
	-	-	-	-	-	-

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

3	Монгол хүний хөгжлийн цогц судалгаанд үндэслэн төрөөс хүн ам, гэр бүл, хүүхэд, залуучууд, хөдөлмөрийн болон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, шилжин суурьшигчдын эрхийг хамгаалах, нийгмийн суурь үйлчилгээг тэгш хүргэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар баримтлах бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж, салбар дундын бодлого зохицуулалтыг сайжруулна.					
	1	5	2	-	2	472,310.0 /УТ/ 24,360.0 /ГЗТ/
4	Нийгмийн халамжийн тусламж, дэмжлэг, үйлчилгээг зорилтот, эмзэг бүлгийн хэрэгцээнд нийцүүлж, амьжиргааг нь дээшлүүлэхэд чиглүүлнэ.					
	1	1	-	-	1	76,600.0 /УТ/
5	Нийгмийн халамж хүртэгсдийн мэдээллийн санг блокчейн технологид суурилан боловсронгуй болгож, нийгмийн хамгааллын үйл ажиллагааг сайжруулна.					
	1	3	1	-	1	400.0 /ГЗТ/
6	Зорилтот бүлгийн өрхийг хөгжүүлэх, хамгаалах, тэдгээрийн амьжиргааг дээшлүүлэх орон нутгийн онцлогт нийцсэн шинэ төрлийн асрамжийн болон олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг нэвтрүүлнэ.					
	-	-	-	-	-	-
7	Эхний ээлжид эмзэг бүлгийн өрхийн нэг гишүүнийг ажлын байраар хангах бодлого баримтална.					
	-	2	3	-	2	106,600.0 /УТ/ 95,800.0 /УТ, ГЗТ/
8	Зайлшгүй орон байраар хангагдах шаардлагатай зорилтот бүлгийн иргэдийг төрийн өмчийн халамжийн түр орон сууцаар хангадаг тогтолцоог нэвтрүүлнэ.					
	-	-	-	-	-	-
9	Орлогын тэгш бус байдлыг багасган нийгмийн суурь үйлчилгээг тэгш хүргэж, нийгмийн зорилтот болон ялгаатай бүлгүүдийн эрх, тэгш оролцоог хангана.					
	1	4	-	-	1	160,369.6 /УТ/

Эх сурвалж: МУ-ын хөгжлийн бодлогын баримт бичгүүд /Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс харна уу/

1.9. Урт хугацааны хөгжлийн бодлогод тусгасан зарим арга хэмжээ нь дунд болон богино хугацааны баримт бичигт тусгагдаагүй байна. Тухайлбал:

- Өрхийн хүнсний баталгаат байдал алдагдахаас зорилтот, эмзэг бүлгийн хүн амыг хамгаалах нийгмийн хамгааллын арга хэмжээг бэхжүүлэх.
- Зайлшгүй орон байраар хангагдах шаардлагатай зорилтот бүлгийн иргэдийг төрийн өмчийн халамжийн түр орон сууцаар хангадаг тогтолцоог нэвтрүүлэх.

1.10. Энэ нь ХБТТУТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.3-т “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг нь дунд болон богино хугацааны бодлого, төлөвлөлтийн үндэс байна” гэж заасантай бүрэн нийцээгүй, бодлогын баримт бичгүүдийн уялдаа хангагдаагүйг харуулж байна.

1.11. Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд нийгмийн халамжийн чиглэлээр туссан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшнийг тодорхойлсон байдлыг авч үзэхэд зарим арга хэмжээний үзүүлэлтүүдийг тодорхойлоогүй байна.

Хүснэгт 4. Шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшнийг тодорхойлсон байдал

№	Бодлогын баримт бичиг	Хэрэгжүүлэх нийт арга хэмжээний тоо	Тодорхойлоогүй үзүүлэлтийн тоо		
			Шалгуур үзүүлэлт	Суурь Түвшин	Зорилтот түвшин
1	Алсын хараа-2050	9	6	6	6
2	МУЗГҮАХ 2020-2024	14	14	-	-

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

3	МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	4	2	2	2
4	МУ-ын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө	7	-	-	
5	МУ-ын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө	-	-	-	-
	Нийт	28	22	8	8

Эх сурвалж: МУ-ын хөгжлийн бодлогын баримт бичгүүд /Дэлгэрэнгүйг хавсралт 2-оос харна уу/

1.12. Шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин тодорхойгүй арга хэмжээнээс дурдвал:

Алсын хараа-2050:

- Нийгмийн халамж хүртэгсдийн мэдээллийн санг блокчейн технологид суурилан боловсронгуй болгож, нийгмийн хамгааллын үйл ажиллагааг сайжруулна.
- Зорилтот бүлгийн өрхийг хөгжүүлэх, хамгаалах, тэдгээрийн амьжиргааг дээшлүүлэх орон нутгийн онцлогт нийцсэн шинэ төрлийн асрамжийн болон олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг нэвтрүүлнэ.
- Зайлшгүй орон байраар хангагдах шаардлагатай зорилтот бүлгийн иргэдийг төрийн өмчийн халамжийн түр орон сууцаар хангадаг тогтолцоог нэвтрүүлнэ.
- Өрхийн амьжиргааны түвшнийг тогтоох аргачлалыг боловсронгуй болгож, гэр бүлийн гишүүн бүрд үзүүлэх нийгмийн халамжийн тусламж, дэмжлэгийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Өрхийн хүнсний баталгаат байдал алдагдахаас зорилтот, эмзэг бүлгийн хүн амыг хамгаалах нийгмийн хамгааллын арга хэмжээг бэхжүүлнэ.
- Монгол хүний хөгжлийн цогц судалгаанд үндэслэн төрөөс хүн ам, гэр бүл, хүүхэд, залуучууд, хөдөлмөрийн болон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, шилжин суурьшигчдын эрхийг хамгаалах, нийгмийн суурь үйлчилгээг тэгш хүргэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар баримтлах бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж, салбар дундын бодлого зохицуулалтыг сайжруулна.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл:

- Нийгмийн халамж зорилтод бүлэгт хүрч, халамжийн үйлчилгээ ил, тод нээлттэй, чирэгдэлгүй болно.
- Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлнэ.

1.13. Энэ нь ХБТТУТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.4⁴, 4.1.6⁵, 6 дугаар зүйлийн 6.7.1.а⁶ дахь заалттай нийцээгүй бөгөөд бодлогын баримт бичгийн гүйцэтгэлийг тоон болон чанарын үзүүлэлтээр үнэлэх боломжийг хязгаарлаж байна.

⁴ "Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого" гэж Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлэх, дэлхий нийтийн хөгжлийн түгээмэл хандлагыг өөрийн орны онцлогт тохируулан тусгасан, байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалах, хүний хөгжлийг хангах, эдийн засаг, нийгэм, засаглалын хөгжлийг ахисан түвшинд хүргэхэд чиглэсэн урт хугацааны зорилго, зорилт, хүрэх үр дүн, үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлтийг тусгасан баримт бичгийг

⁵ "Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" гэж Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн, Хөгжлийн зорилтот хөтөлбөрт нийцүүлсэн улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн уялдааг хангасан зорилго, зорилт, хүрэх үр дүн, нөөцөд суурилан боловсруулсан төсөл, арга хэмжээг агуулсан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, тоон болон чанарын шалгуур үзүүлэлт бүхий дунд хугацааны нэгдсэн төлөвлөлтийн баримт бичгийг

⁶ урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилтын тухайн таван жилд хүрэх үр дүн, тоон болон чанарын шалгуур үзүүлэлт, тухайн шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх зорилтот түвшнийг тодорхойлсон байх

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

1.14. Иймд бодлогын баримт бичигт тусгагдан хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг тодорхой болгож үе шат бүрийн хэмжих, үнэлэх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна. Бодлогын зорилго, зорилтын хэрэгжилтийг бодитой үнэлэх боломжгүй байгаагаас зорилгод хүрэх зорилт биелж эерэг өөрчлөлт бий болгож байгаа эсэх бодлогын үр нөлөөг тооцох боломжгүй үр дагавар үзүүлж байна.

Бодлогын баримт бичигт тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн хөтөлбөргүй, зарим үйл ажиллагааны санхүүжилтийг бодитой төлөвлөөгүй байна

1.15. ХБТТУТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.5-д “Дунд хугацаанд хэрэгжих хөгжлийн бодлогын баримт бичиг нь урт хугацааны бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд чиглэсэн салбар тус бүрд өөр өөрийн зорилтот хөтөлбөртэй байх”-аар заасан боловч нийгмийн хамгааллын салбарт 2023 оны 11 дүгээр сарын байдлаар батлагдсан хөтөлбөргүй байна.

1.16. Хөгжлийн бодлогын баримт бичигт нийгмийн халамжийн чиглэлийн зарим арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийн талаар тусгаагүй байгаа нь ХБТТУТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.6⁷-д заасан зарчим алдагдсан, төлөвлөлтийн баримт бичгийг төлөвлөхдөө хөрөнгө санхүү, ажиллах хүчний нөөцийг урьдчилан тооцоолсон төлөвлөлт хийгдээгүй байна. Энэ нь тухайн зорилгод хүрэхээр хэрэгжүүлж буй зорилтын хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны өртгийг тооцох боломжгүй болгох үр дагавар үзүүлж байна.

1.17. Дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд нийгмийн халамжийн талаар хэрэгжүүлэх 28 арга хэмжээний 15-т улсын төсвөөс 920.5 тэрбум төгрөг, гадаад эх үүсвэрүүдээс 24.7 тэрбум төгрөг нийт 945.2 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн боловч энэхүү санхүүжилтийн талаар хийгдсэн тооцоо судалгаа, дэлгэрэнгүй мэдээлэл байхгүй байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүжилтийн хэмжээ тодорхойгүй байна

1.18. ХНХС-ын 2021 оны А/205 дугаар тушаалаар “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө”-г баталсан байна.

1.19. Уг стратеги төлөвлөгөөнд нийгмийн халамжийн чиглэлээр 3 зорилтын хүрээнд 9 стратеги хэрэгжүүлэхээр тусган шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтод түвшнийг тодорхойлсон байна.

Хүснэгт 5: Стратеги төлөвлөгөөнд туссан нийгмийн халамжийн чиглэлээрх зорилт

№	Зорилт	Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх стратегийн тоо
1	Хүн ам, гэр бүлийн хөгжил, хамгааллын тогтолцоог бэхжүүлнэ.	2
2	Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдлийг бууруулах замаар иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.	1
3	Зорилтот иргэн, даатгуулагчид нийгмийн хамгааллын үйлчилгээг хүргэж, нийгмийн баталгаагаар хангах.	6
Нийт		9

Эх сурвалж: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө /Хавсралт 3-аас харна уу/

1.20. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүжилтийн хэмжээ тодорхойгүй байгаа нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний

⁷ Нөөц, эх үүсвэрт үндэслэсэн байх.

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6-д “нөөц эх үүсвэрт үндэслэсэн байх” гэж заасантай нийцэхгүй байна.

1.21. Харин салбарын стратеги төлөвлөгөөний 3.5-д заасан “Зорилтот өрх, иргэдийн амьдралын нөхцөл, амьжиргааны түвшнийг дээшлүүлэх” зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ХНХ-ын яамны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан зарим арга хэмжээнд НЗДТГ-тай хамтран шаардлагатай санхүүжилтийг Азийн хөгжлийн банкны “Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2”-ын хүрээнд туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 1.7 сая ам.долларын төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

1.22. Мөн Нийгмийн даатгал, нийгмийн халамжийн хүний нөөцийг чадавхжуулах сургалтын платформ, хөтөлбөрийг боловсруулж, салбарын ажилтан, алба хаагчид, гэрээт төрийн бус байгууллагыг чадавхжуулах зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Дэлхийн банкны “Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд нийгмийн халамжийн салбарын ажилтнуудад зориулсан сургалтыг зохион байгуулахаар нийт 80.0 мянган ам.доллар зарцуулахаар төлөвлөжээ.

1.23. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын стратеги төлөвлөгөө нь бодлогын зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн оновчтой, хэмжигдэхүйц, тодорхой хугацаанд хүрч болохуйц арга хэмжээ буюу үйл ажиллагааг тодорхойлоогүй байна.

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

БҮЛЭГ 2: Нийгмийн халамжийн талаарх хууль, эрх зүйн шинэчлэл бүрэн хийгдээгүйгээс зарим арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан нийгмийн халамжийн талаар авч хэрэгжүүлсэн нийт 14 арга хэмжээний 2 нь үр дүнд хүрсэн, 6 нь тодорхой үр дүнд хүрсэн, 6 арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байна.

2.1. Монгол Улсын ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр⁸, төлөвлөгөөнд⁹ туссан нийгмийн халамжийн талаар авч хэрэгжүүлсэн зорилт, зорилтын хэрэгжилтийн үнэлгээг 2023 оны эхний хагас жилийн байдлаар нэгтгэн харуулбал:

Хүснэгт 6. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан нийгмийн халамжийн талаар авч хэрэгжүүлсэн зорилтуудын үр дүнгийн үнэлгээний нэгтгэл.

№	Зорилт	Арга хэмжээний тоо	Арга хэмжээний хэрэгжилт		
			Үр дүнтэй /100/	Тодорхой үр дүнд хүрсэн /70-100/	Эрчимжүүлэх шаардлагатай /30-70/
1	2.5.5. Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг инфляц, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлнэ.	1	100		
2	2.5.6. “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй болгоно.	1	100		
3	2.5.7. Өрхийн амьжиргааны түвшнийг тогтоох аргачлалыг боловсронгуй болгож, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг тууштай бууруулна.	4		85	
4	2.5.8. Гэр бүл, хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дээдэлсэн, нийгмийн бүх бүлгийн оролцоог хангасан хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ.	5			47.1
5	2.5.9. Орлого багатай өрхийн ажил эрхлэхгүй байгаа насанд хүрсэн гишүүдийг мэргэшил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.	1		70	
6	2.5.12. “Хуримтлалтай хүүхэд” арга хэмжээ хэрэгжүүлж, хүүхдийн мөнгийг тэдний хүнс, тэжээлийн хэрэгцээ, бие бялдар, хувь хүний хөгжил, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, хүүхдийн хуримтлал бий болгоход зарцуулах тогтоог бүрдүүлнэ.	1			30
7	2.5.13. Тусгай хэрэгцээ /байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээл/-тэй 0-16 насны хүүхдээ асран ажил хөдөлмөр эрхэлж	1		70	

⁸ УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан.

⁹ ЗГ-ын 2020 оны 203 дугаар тогтоолоор баталсан.

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

чадахгүй байгаа эх /эцэг/-ийн нийгмийн даатгалын шимтгэлийг төрөөс төлөх боломжоор хангах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.				
---	--	--	--	--

Эх сурвалж: ХНХ-ын яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын үнэлгээний тайлан.

2.2. Эдгээр зорилго, зорилтын хэрэгжилтийг шалгуур үзүүлэлт, хүрэх түвшиндээ бүрэн хүрсэн эсэхийг авч үзэхэд дараах байдалтай байна.

Зорилт 2.5.5	“Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг инфляц, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлнэ” гэсэн зорилтын хүрээнд Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг бүсүүдийн хүн амын амьжиргааны түвшний дундажтай тэнцүү болгож нэмэгдүүлнэ гэсэн зорилгыг хэрэгжүүлэхээр ажилласан байна.
---------------------	--

2.3. Уг зорилтын хүрээнд ЗГ-ын 2020 оны 25, 2023 оны 237 дугаар тогтоолуудаар нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоосон байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 7. Нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тогтоолд орсон өөрчлөлтүүд /мянган төгрөг/

№	Нэр төрөл	ЗГ-ын 2019 оны 27 дугаар	ЗГ-ын 2020 оны 25 дугаар	ЗГ-ын 2023 оны 237 дугаар
1	Нийгмийн халамжийн тэтгэвэр /сар бүр/	174.0	288.0	325.0
2	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэнд олгох асаргааны тэтгэмж /сар бүр/	114.0	123.1	275.0
3	Бусад асаргааны тэтгэмжийн хэмжээг /сар бүр/	76.0	84.5	

2.4. Эдгээр тогтоолуудын дагуу 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийгмийн халамжийн сангаас давхардсан тоогоор 57,378 иргэнд нийт 92.4 тэрбум төгрөгийн асаргааны тэтгэмжийг олгосон байна.

Зорилт 2.5.6	“Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахим хэлбэрт шилжүүлж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй болгоно” гэсэн зорилтын хүрээнд хүрэх түвшнийг “Нийгмийн халамжийн үйлчилгээний 30 хувийг 2021 онд, 60 хувийг 2022 онд, 80 хувийг 2023 онд цахимжуулсан байна” гэж тодорхойлсон байна.
---------------------	---

2.5. Нийгмийн халамжийн үйлчилгээг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлж халамжийн нэгдсэн систем буюу www.ehalamj.mn цахим системийг 2020 онд нэвтрүүлж нийгмийн халамжийн чиглэлээр үзүүлж байгаа 72 үйлчилгээнээс 67 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлсэн байна.

2.6. Иргэд e-mongolia, www.ehalamj.mn цахим хуудас, төрийн үйлчилгээний цахим машин “ТҮЦ” машин, ebarimt аппликэйшнийг ашиглан нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах хүсэлтээ гаргаж, үйлчилгээг бүрэн авах боломжтой болсон байна.

2.7. Цахим хэлбэрт шилжүүлснээр төрийн байгууллага болон халамжийн үйлчилгээ авч байгаа иргэдийн хувьд зарим зардлууд хэмнэж, ил тод байдлыг хангасан байна. Тухайлбал,

- /eHalatj/ системээс багцын гүйлгээ хийдэг болсноор арилжааны банкны үйлчилгээний хураамжийн зардлыг хэмнэж 2022 он 197.5 сая төгрөг хэмнэсэн,

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

- *Иргэдэд цахим хувийн хэрэг үүсэж хувийн хэрэг болон дэвтэр хэвлэх зардлыг 2022 онд 52,1 сая төгрөг, 2023 оноос 137,7 сая төгрөг тус тус хэмнэсэн байна.*
- *Иргэдийн техник технологийн орчинд, цахим орчинд ажиллах арга барилыг нэмэгдүүлсэн /халамжийн үйлчилгээг цахимжуулснаар иргэн гэрээсээ, ажлаасаа байршил харгалзахгүйгээр хүссэн газраасаа халамжийн үйлчилгээнд хамрагдах хүсэлтээ цахимаар илгээх боломжтой болсон/*
- *Иргэн өөрийн гаргасан өргөдөл, хүсэлтийнхээ шийдвэрлэлтийн явцад хяналт тавих боломжтой болсон.*
- *Төрийн байгууллага хоорондоо мэдээллээ солилцсоноор нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэд цээж зураг авхуулах, хувийн хэрэгт хавсаргах тодорхойлолт бусад материал, мөн нотариатаар батлуулах гэх мэт зардлууд хэмнэсэн байна.*

2.8. Үүнээс үзэхэд Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд дэвшүүлсэн 2.5.6 зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрсэн байна.

**Зорилт
2.5.7**

“Өрхийн амьжиргааны түвшнийг тогтоох аргачлалыг боловсронгуй болгож, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг тууштай бууруулна” гэсэн зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

2.9. Нэг. “Нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх, халамжийн мөнгөн дүнг нэмэгдүүлэх, орчин үеийн стандартыг нэвтрүүлэх зорилгоор эрх зүйн шинэчлэл хийж, хэрэгжүүлнэ” гэсэн арга хэмжээний хүрээнд дараах хүрэх түвшин, үр дүнг тодорхойлсон байна. Үүнд:

- *2021 онд Хуулийн төслийг батлуулсан байна.*
- *2022 онд нийгмийн халамжийн тухай хуулийн төслийг УИХ-аар батлуулж,*
- *2023 онд Хууль тогтоомжийн шинэчлэлтэй уялдуулсан журам, зохицуулалт, аргачлалууд батлагдсан байна.*

2.10. Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ХНХ-ын яам холбогдох яамдаас саналыг авч нэгтгэн боловсруулж, ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2021 оны 10 дугаар сард албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн ч 2022 оны 8 дугаар сард ЗГ-ын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбоотой хуулийн төслийг 2022 оны 9 сард ЗГХЭГ-т буцаасан байна.

2.11. Үүнтэй холбогдуулан яам, агентлагийн ажлын хэсэг 2023 оны 3-4 дүгээр сард Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дахин сайжруулах, холбогдох баримт бичгийн тоо мэдээллийг шинэчилж Нийгмийн халамжийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл, дагалдах хуулийн төслүүд, тандан судалгаа, зардлын тооцоог дахин боловсруулж ажилласан байна.

2.12. Тус хууль ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан хугацаандаа УИХ-аар батлагдаагүйгээс дээрх зорилт хүрэх түвшиндээ хүрээгүй байна.

2.13. Уг хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орохоор хуулийн төслийг шинэчилсэн найруулгын төсөл хэлбэрээр боловсруулсан байна. Хуулийн төсөлд нь нийгмийн халамжийн үйлчилгээний төрөл, хэлбэр, хамрах хүрээг тогтоох, нийгмийн халамжийн сан бүрдүүлэх, уг сангийн хөрөнгийг хуваарилах, зарцуулах, тайлагнах, хяналт

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

тавих болон нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо зэрэг нийгмийн халамжийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахаар байна.

2.14. Тус хууль зорилтод заасан хугацаандаа батлагдсанаар Нийгмийн халамжийн тэтгэмжийг халамж шаардлагатай зорилтот хэсэгт чиглүүлж, сангийн зарцуулалтын эрх зүйн орчин сайжрах үр дагавартай байсан байна.

2.15. **Хоёр.** “Цалинтай ээж” хөтөлбөрийг үргэлжлүүлж, 3 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдэд ялгаварлалгүй олгоно” гэсэн арга хэмжээний хүрээнд дараах хүрэх түвшин, үр дүнг тодорхойлсон байна. Үүнд:

- 3 хүртэлх насны хүүхэдтэй бүх эхчүүд хөтөлбөрт бүрэн хамрагдсан байна.

2.16. 2017 онд баталсан ЭЭОХӨТЭЭТОТХ-ийн дагуу жирэмсэн эх, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх, эцэг, дөрөв хүртэлх насны ихэр хүүхэдтэй эх, эцэг, гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгохтой холбоотой хуулийн үйлчилгээнд 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 215 833 иргэнд 54.1 тэрбум төгрөг олгосон байна.

2.17. Уг хуулийг 2021 оны 5 дугаар сарын 06-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулснаар 0-3 насны хүүхэд асарсны тэтгэмж авч байсан эх хүүхдээ 3 нас хүрэхээс өмнө ажилд орсон тохиолдолд тэтгэмжийг хүүхдээ асарч байгаа эцэгт нь олгох эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлсэн. Уг нэмэлт өөрчлөлтийн хүрээнд 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 160646 эх, эцэг хамрагдаж, 39.9 тэрбум төгрөг зарцуулсан байна.

2.18. Тус зорилт нь тодорхойлсон хүрэх түвшиндээ хүрсэн байна.

2.19. **Гурав.** Ахмад настны амьжиргааг дэмжиж, орлогын баталгааг хангах зорилгоор “Насны хишиг” тэтгэмжийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

2.20. 2020 оны байдлаар орлогын баталгааг хангах зорилгоор насны хишиг тэтгэмжийг 138 383 ахмадад 22.8 тэрбум төгрөг олгосон байна.

2.21. Насны хишиг тэтгэмж нь ахмад настнуудын эрүүл насжих, тэдний орлогын баталгааг бууруулахгүй байхад чиглэсэн томоохон дэмжлэг болж 2023 оны эхний хагас жилийн байдлаар 65 ба түүнээс дээш настай 175 136 ахмад настанд 26.5 тэрбум төгрөгийн насны хишиг тэтгэмжийг олгосон байна.

2.22. Тус зорилтын хэрэгжилт зорилтод түвшиндээ чиглэгдэн үр дүнтэй хэрэгжсэн байна.

**Зорилт
2.5.8**

“Гэр бүл, хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дээдэлсэн, нийгмийн бүх бүлгийн оролцоог хангасан хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ” гэсэн зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

2.23. **Нэг.** “Хүн амын бүлгүүдийн хөгжлийг дэмжих асуудлаарх эрх зүйн орчныг шинэчилж, шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлнэ” гэсэн арга хэмжээний хүрээнд дараах хүрэх түвшин, үр дүнг тодорхойлсон байна. Үүнд:

- 2021 онд Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиудын төслийг УИХ-аар батлуулсан байна.
- 2022 онд Хуулиудын хэрэгжилтийг хангах хүрээнд холбогдох дүрэм журмыг батлуулсан байна.
- 2023 онд Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиудын хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

Хүүхдийн эрхийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хувьд:

2.24. ХНХ-ын яамнаас Хүүхдийн төлөө санг сэргээн байгуулах ажлын хүрээнд ЗГ-ын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай болон Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулж 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэн батлуулж, Хүүхдийн төлөө санг сэргээн байгуулсан байна. Үүнд:

- *Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6¹⁰, 16.7¹¹ гэсэн заалтыг нэмэлтээр тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.*
- *Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21^{2.4}¹² дэх заалтын дагуу "Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам"-ыг ЗГ 2021 оны 172 дугаар тогтоолоор батлуулсан байна.*

Сангийн зорилт. Хүүхдийн төлөө сангаас хүүхдийн хөгжлийг дэмжсэн бүтээн байгуулалт, олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээнд амжилт гаргасан хүүхдийг шагнаж, урамшуулах, мөн олон улс, тив, дэлхийн уралдаан тэмцээнд оролцох болзол хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэмжлэг үзүүлнэ.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хувьд:

2.25. ХНХ-ын яамнаас Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10.5¹³ гэсэн заалт нэмэлтээр оруулж 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганаар батлуулсан байна. Тус нэмэлт өөрчлөлт батлагдсанаар хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг тооцох, санхүүжүүлэх эрх зүйн зохицуулалттай болсон байна. ХНХС-ын 2021 оны А/218 тушаалаар "Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам"-ыг баталсан байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хувьд:

2.26. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах үзэл баримтлалыг 2021 онд ХНХС, ХЗДХС нар баталж, баталсан үзэл баримтлалын хүрээнд хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, 20 гаруй удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж, 2021 оны 5 дугаар сарын 31-ний өдөр ЗГ-ын хуралдаанаар танилцуулж, 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдөр ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.

2.27. Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр ЗГ-аас өргөн мэдүүлсэн. УИХ-ын чуулганы 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, хэлэлцэхийг УИХ-аас дэмжсэн байна. Тус хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 7 бүлэг, 59 зүйлтэй боловсруулсан байна.

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хувьд:

2.28. УИХ-аас Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг 2017 онд баталж, 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжүүлж, залуучуудын хувь хүний хөгжил, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, оролцоог дэмжих бодлого, арга хэмжээг хэрэгжүүлж байна.

¹⁰ 16.6. "Хүүхдэд зориулсан бүтээн байгуулалт, хүүхдийн хөгжил, хамгаалал, оролцоог дэмжих зориулалт бүхий Хүүхдийн төлөө сантай байна"

¹¹ 16.7. "Энэ хуулийн 16.6-д заасан сангийн удирдлага, сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хянахтай холбогдсон харилцааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулна.

¹² 21^{2.4} Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар батална.

¹³ 10.5. "Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмыг хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх аргачлалыг хүүхэд хамгааллын болон төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтарч батална"

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбогдуулан тандалт, судалгааны тайланг Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйл, ЗГ-ын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан. Тайлангаас харахад,

2.29. МУ-ын Ерөнхий сайд хүүхдийн хөгжил, хамгааллын байгууллагуудын төлөөлөлтэй 2023 оны 05 дугаар сард уулзалт хийж, ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын чиг үүргийг өөрчилж, хүүхэд, гэр бүлийн асуудалд төвлөрсөн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хөгжлийн ерөнхий газар болгохоор тогтсон. Үүнтэй холбогдуулан залуучуудын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын залуучуудын хөгжлийг дэмжихтэй холбоотой чиг үүргийг төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэгт тусгаж, зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэхтэй холбоотой өөрчлөлтийг хуулиар зохицуулах шаардлагатай болсон байна.

2.30. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасан Залуучуудын хөгжлийг дэмжих сан нь Засгийн газрын тусгай санд заасан зарим сангаас санхүүжүүлэх үйл ажиллагааны чиглэлтэй давхацсан, холбогдох бусад сангуудаас санхүүжүүлэх арга хэмжээний хүрээнд хэрэгжилт хангагдаж байгааг харгалзан цаашид тус сантай хамаарах заалтыг хүчингүй болгох, сангаас санхүүжүүлэх арга хэмжээг залуучуудын хөгжил, оролцоог дэмжих бусад санхүүжилт, төсөвлөлтөд тусгах шаардлагатай болсон зэрэг болно. Тус хуулийг УИХ-ын 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулж дараах зохицуулалтуудыг тусгасан байна. Үүнд:

- *Залуучуудын асуудлаарх Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн зарим чиг үүргийг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шилжүүлсэн;*
- *Орон нутагт Залуучуудын хөгжлийн төв ажиллах эрх зүйн зохицуулалтыг баталж, төвийн зарим чиг үүргийг магадлан итгэмжилсэн иргэний нийгмийн байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх боломжтой болсон, магадлан итгэмжлэх журмыг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлах тухай зохицуулалтыг тусгасан;*

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хувьд:

2.31. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төсөл, хуулийн тандан судалгаа, үр нөлөөний судалгаа, зардлын тооцоог боловсруулж. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг дагалдан 20 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулсан. Хуулийн төслийн үзэл баримтлалыг 2021 онд батлуулж байсан бөгөөд ЗГ-ын бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбогдуулан үзэл баримтлалыг дахин батлуулахаар болсон байна. Хуулийн төслийг төр, төрийн бус байгууллагад нийт 7 удаа хэлэлцүүлсэн бөгөөд хамгийн сүүлд 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр хэлэлцүүлж, саналыг тусган ажилласан байна.

2.32. Тус зорилтын хүрээнд зарим хуулиуд эрх зүйн шинэчлэл хийгдсэн ч Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль ЗГ-ын бүтэц өөрчлөгдсөнтэй холбоотойгоор зорилтод түвшиндээ бүрэн хүрээгүй тус хуулийг шинэчлэн найруулж УИХ-аар батлуулаагүй байна.

2.33. **Хоёр.** “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн амьдралд саадгүй оролцох, хүртээмжийг сайжруулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ” гэсэн арга хэмжээний хүрээнд дараах хүрэх түвшин, үр дүнг тодорхойлсон байна. Үүнд:

- *2021 онд хуулийг УИХ-аар батлуулсан байна.*
- *2022 онд хуулийн хүрээнд холбогдох дүрэм журмыг боловсруулан батлуулсан байна.*
- *2023 онд хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.*

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

2.34. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн амьдралд саадгүй оролцох, хүртээмжийг сайжруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилтын хүрээнд саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийн төслийг ХНХ-ын яам хуулийн төслийг боловсруулах ажил хийгдэж байна. Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3¹⁴ дах заалтын дагуу Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг 2023 оны 11 сарын байдлаар батлуулаагүй байна.

2.35. Хууль зүйн үндсэн шаардлагын хувьд: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцод МУ 2009 онд нэгдэн орсноор тус конвенцын үзэл баримтлалд нийцүүлэн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах талаар дотоодын хууль тогтоомжоо боловсронгуй болгох, холбогдох зохицуулалтыг сайжруулах, шаардлагатай тохиолдолд шинээр хууль боловсруулах үүргийг хүлээсэн.

2.36. Практик шаардлагын хувьд: Үндэсний статистикийн хорооны 2022 оны жилийн эцсийн мэдээгээр МУ-д 115.1 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүн байгаа нь нийт хүн амын 3.3 хувийг эзэлж байна. Аймгийн төвүүд, хот суурин газар, нэн ялангуяа нийт хүн амын 50-аас дээш хувь суурьшсан нийслэл Улаанбаатар хотын хувьд хот төлөвлөлт алдагдаж, холбогдох стандарт, норм дүрмийн шаардлага хангаагүй орон сууц болон олон нийтийн зориулалттай барилга байгууламж, авто замын байгууламж, гудамж, зам талбай шинээр ашиглалтад орж байгаагаас хөгжлийн бэрхшээлтэй хүн, хүүхэд, ахмад настан, жирэмсэн эмэгтэйчүүд зэрэг зорилтот бүлгийн иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөдөлмөрлөх эрх хангагдахгүй байна. Нөгөө талаас шинээр байгуулагдаж байгаа телевиз, веб сайт зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн хүртээмжгүй байдал нь хараа, сонсголын бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг зөрчиж байна.

2.37. Зорилтын хүрэх түвшин үр дүнгийн шалгуур үзүүлэлтэд заасны дагуу 2021 онд хуулийг УИХ-аар батлуулж, 2022 онд хуулийн хүрээнд холбогдох дүрэм журмыг боловсруулан батлуулж, 2023 онд хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахаар зорилт дэвшүүлсэн ч 2023 оны 11 сарын байдлаар хуулийн төслийн үзэл баримтлал батлагдаагүй байгаа нь тус зорилт хангагдаагүй үр дүнгүй ажилласан байна.

2.38. **Гурав.** “Хүн амын амьдралын таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн Хүний амын хөгжлийн зорилтот хөтөлбөр, хүүхэд, залуучууд, ахмад настан, удмын сан, гэр бүл, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, хөгжил, хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлнэ” гэсэн арга хэмжээний хүрээнд дараах хүрэх түвшин, үр дүнг тодорхойлсон байна. Үүнд:

- 2022 онд Хөгжлийн зорилтот хөтөлбөр, арга хэмжээний нэгдүгээр шатны (2022-2024) хэрэгжилтийн төлөвлөгөөг сайдын тушаалаар баталж, хэрэгжилт 20-оос доошгүй хувьд хүрсэн байна.
- 2023 онд Хөгжлийн зорилтот хөтөлбөр, арга хэмжээний нэгдүгээр шатны (2022-2024) төлөвлөгөөний хэрэгжилт 60-аас доошгүй хувьд хүрсэн байна.

2.39. Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлын хэсэг, ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнийг 2021 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн МУ-ын ЗГХЭГ-ын даргын 50 дугаар тушаалаар баталсан байна. Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлыг удирдан зохион байгуулах ажлын хэсэг 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн МУ-ын Ерөнхий сайдын 57 дугаар захирамжаар баталсан.

2.40. Тус Хөгжлийн зорилтод хөтөлбөр 2030 төслийг 28 зорилт 95 зорилго, 374 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр төсөл боловсруулсан ч 2023 оны эхний хагас жилийн байдлаар

¹⁴ 15.3. Засгийн газрын санаачлах хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

эцэслэн батлагдаагүй байгаа нь тус зорилт үйл ажиллагааны хөтөлбөрт заасан хэрэгжилт хангагдаагүй байна. Уг хөгжлийн зорилтод хөтөлбөрийн төслийн зорилтын 6.3-т “Нийгмийн халамжийн үйлчилгээний хүртээмжийг оновчтой болгоно” гэсэн зорилтод дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр байсан байна. Үүнд:

6.3.1. Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлгийн иргэдийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн шинэчилнэ.

6.3.2. Нийгмийн халамжийн зорилтот бүлгийн иргэдийн хандлага, төлөвшилийг өөрчлөх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулан, бие даан амьдрах чадварыг дээшлүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

2.41. **Дөрөв.** “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангаж, нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлж, олон улсын жишигт нийцсэн үйлчилгээг нэвтрүүлнэ” гэсэн арга хэмжээний хүрээнд дараах хүрэх түвшин, үр дүнг тодорхойлсон байна. Үүнд:

- 2021 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвүүдийн барилгын ажлыг эхлүүлсэн байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн барилгын ажлыг эхлүүлсэн байна. Тооцоолол, зураг төслийг боловсруулж, батлуулсан байна.
- 2022 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвүүдийн барилгын ажлыг бүрэн дуусгасан байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн барилгын ажлыг бүрэн гүйцэтгэсэн байна. Спорт цогцолборын барилгын ажлыг эхэлсэн байна.
- 2023 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвүүдэд шинэ үйлчилгээнүүдийг нэвтрүүлж, үйлчлүүлсэн хүний тоо 2500-д хүрсэн байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамрагдах боломж, хүртээмж нэмэгдсэн байна. Спорт цогцолборын барилгын ажлыг бүрэн гүйцэтгэсэн байна.

2.42. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв байгуулах: Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 2021 онд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн хүрээнд Улаанбаатар хот, Ховд, Хөвсгөл, Архангай, Дархан-Уул, Дундговь, Дорнод аймагт олон улсын стандартад нийцсэн, түгээмэл загвар бүхий Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг байгуулахаар төлөвлөсөн байна.

2.43. Үүний дагуу төвийн бүтэц, үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрмийг ХНХС-ын 2022 оны А/159 тушаалаар баталж, Ховд, Хөвсгөл, Дархан-Уул, Дундговь, Дорнод аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг 2022 онд хүлээн авсан байна. Харин Улаанбаатар хот, Архангай аймагт баригдаж байгаа төвийн барилгын явц 50-70 хувийн гүйцэтгэлтэй байна. Ашиглалтад орсон төвийн үйл ажиллагааг 2023 оны 9 дүгээр сараас эхлэн 10 дугаар сарын байдлаар 2053 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настанд үзлэг, сургалт мэдээлэл, эмчилгээ, зөвлөгөөний үйлчилгээг үзүүлсэн байна.

2.44. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спорт цогцолборын барилгын ажил: БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 20.4 сая ам.долларын төсөвт өртөгтэйгөөр “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спорт цогцолбор”-ыг барихаар шийдвэрлэсэн байна. Монголын талаас хариуцан гүйцэтгэх инженер геологийн судалгаа хийгдэж, холбогдох техникийн нөхцөлүүд, байл орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээнүүдийг холбогдох байгууллагаар хийлгэн БНХАУ-ын талд уламжилсан. Спорт цогцолбор барих асуудлаарх “Солилцох захидал”-ыг төслийг боловсруулан 2023 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 02/492 дугаартай албан тоотоор гадаад харилцааны яаманд хүргүүлсэн байна. МУ-ын ерөнхийлөгч БНХАУ-д хийсэн төрийн айлчлал үеэр ХНХС, БНХАУ-ын Худалдааны яамны сайд нар БНХАУ-ын

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

буцалтгүй тусламжийн хүрээнд 20.4 сая ам.долларын төсөвт өртөгтэй барилгын ажлыг хоёр талын ЗГ хамтын ажиллагааны хүрээнд эхлүүлэхээр болсон байна.

2.45. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангаж, нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлж, олон улсын жишигт нийцсэн үйлчилгээг нэвтрүүлэх зорилт хүрэх түвшинд зарим үзүүлэлт хүрч байгаа боловч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ удаашралтай байна.

**Зорилт
2.5.13**

“Тусгай хэрэгцээ /байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээл/-тэй 0-16 насны хүүхдээ асран ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа эх /эцэг/-ийн нийгмийн даатгалын шимтгэлийг төрөөс төлөх боломжоор хангах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ” гэсэн зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

2.46. “Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй 0-16 насны хүүхдээ асран ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа эх /эцэг/-ийн нийгмийн даатгалын шимтгэлийг төрөөс төлөх эрх зүйн орчныг бүрдүүлнэ” гэсэн арга хэмжээний хүрээнд дараах хүрэх түвшин, үр дүнг тодорхойлсон байна. Үүнд:

- 2021 онд Нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувийг улсын төсвөөс хариуцан төлөх зохицуулалтыг нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулсан байна.
- 2022 онд Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсан байна.
- 2023 онд Нийгмийн даатгалын шимтгэлийн тодорхой хувийг улсын төсвөөс төлсөн байна.

2.47. ХНХ-ын яамнаас Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгад байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эх эсвэл эцгийн нийгмийн даатгалын шимтгэлийг төрөөс төлөх хуулийн төсөл боловсруулж, хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийг батлуулах үе шатны ажил хийдэж 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр УИХ-аар Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан байна.

2.48. Тус хуулийн шинэчилсэн найруулгын 21 дүгээр зүйлийн 21.22¹⁵ дэх заалтын дагуу Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асран ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа эх /эцэг/-ийн нийгмийн даатгалын шимтгэлийг төрөөс төлөх эрх зүйн орчныг бүрдүүлсэн ч ЗГ мөрийн хөтөлбөрт заасан хугацаандаа буюу 2022 онд батлагдаагүй 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан ч 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс даган мөрдөхөөр батлагдсан байна.

2.49. ЗГ-ын газрын мөрийн хөтөлбөрт заасан хугацаандаа буюу 2022 онд хууль батлагдаж, 2023 онд тус хуулийн 21 дүгээр зүйлийн 21.22 дах заалтыг хэрэгжүүлсэн бол 2023 онд 11400 иргэн хамрагдаж 10.3 тэрбум төгрөгийг улсын төсвөөс зарцуулахаар тооцоо гарч байна. Тооцооллыг Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа эмнэлгийн хяналтад байдаг байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэдийн сүүлийн 5 жилийн дундаж тоонд үндэслэн тооцов.

2.50. Тус зорилтыг ЗГ-ын мөрийн хөтөлбөрт заасан хугацаандаа буюу 2022 онд нэмэлт өөрчлөлт оруулж, 2023 онд улсын төсвөөс нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөн байна

¹⁵ 21.22. Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажил хөдөлмөр эрхлээгүй эх, эсхүл эцэг энэ хуулийн 7.7-д заасны дагуу даатгуулах бол тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийг улсын төсвөөс сар бүр төлнө.

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

гэсэн хугацаандаа хэрэгжүүлээгүй ч 2023 онд нэмэлт өөрчлөлт орж, 2024 оноос хэрэгжиж эхлэхээр хуульд заасан байна.

**Зорилт
2.5.9**

“Орлого багатай өрхийн ажил эрхлэхгүй байгаа насанд хүрсэн гишүүдийг мэргэшил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ” гэсэн зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

2.51. “Хүн амын бүлгүүд, нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд чиглэсэн санхүүгийн бус дэмжлэг үзүүлэх хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлж, хөдөлмөрт бэлтгэх, аж ахуй эрхлэх болон бусад үйл ажиллагааны дэмжлэг үзүүлнэ” гэсэн арга хэмжээний хүрээнд дараах хүрэх түвшин, үр дүнг тодорхойлсон байна. Үүнд:

- 2021 онд Хөтөлбөр, арга хэмжээнд өөрчлөлт оруулж, хэрэгжүүлж эхэлсэн байна.
- 2022 онд Хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.
- 2023 онд Шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг хийж, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

2.52. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021 оны 01 дүгээр, 2022 оны 02 дугаар тогтоолуудаар баталсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2021-2022 онд нийт 13178 иргэн хамрагдаж, 965 иргэн ажлын байраар хангагдаж, 731.3 сая төгрөгийг ХЭДС-аас зарцуулсан байна. Үүнд,

- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээнд 1263 иргэн хамрагдаж, 8.5 сая төгрөг,
- Ажлын байрны харилцаа, сэтгэл зүйн сургалтад 5774 иргэн хамрагдаж, 402 ажлын байр бий болж 164.3 сая төгрөг,
- Ажилд зуучлах уулзалтад бэлтгэх үйлчилгээнд 3457 иргэн хамрагдаж, 237 ажлын байр бий болж 109.2 сая төгрөг,
- Танхимын сургалтад 2684 иргэн хамрагдаж, 326 ажлын байр бий болж 449.3 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

2.53. ХНХС-ын 2023 оны А/16 дугаар “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны нэгдсэн удирдамж, зардлын жишиг хэмжээг батлах тухай” тушаалаар “Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа (хөтөлбөр)-г хэрэгжүүлэх нэгдсэн удирдамж, зардлын жишиг хэмжээ”-г шинэчлэн баталсан байна.

2.54. Хүн амын бүлгүүд, нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд чиглэсэн санхүүгийн бус дэмжлэг үзүүлэх хөтөлбөр, хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хүрээнд зохион байгуулсан ажлын үр дүн хоорондын хамаарал тайлагнагдахгүй байгаа тул зорилтын хэрэгжилтийг хэмжих боломжгүй байна.

**Зорилт
2.5.12**

“Хуримтлалтай хүүхэд” арга хэмжээ хэрэгжүүлж, хүүхдийн мөнгийг тэдний хүнс, тэжээлийн хэрэгцээ, бие бялдар, хувь хүний хөгжил, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, хүүхдийн хуримтлал бий болгоход зарцуулах тогтолцоог бүрдүүлнэ” гэсэн зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

2.55. “Хүүхэд бүрд хүүхэд хөгжлийн карт олгож, сар бүр тус картад хүүхдийн хөгжилд зарцуулах дэмжлэг олгоно” гэсэн арга хэмжээний хүрээнд дараах хүрэх түвшин, үр дүнг тодорхойлсон байна. Үүнд:

- 2021 он Тооцоо, судалгаанд үндэслэн холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулсан байна.
- 2022-2023 он Хүүхэд бүр “Хүүхэд хөгжлийн карт”-тай болсон байна.

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

2.56. Ирээдүйн өв сангийн тухай хууль, ЗГ-ын 2022 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхдийн мөнгөн хуримтлалыг Төрийн санд байршуулан хуримтлуулах, бүртгэх, олгох журам”-ын дагуу 2022 оны эхний 11 сарын байдлаар мөнгөн хэлбэрээр 1,258,239 хүүхдэд, хүүхдийн мөнгөн хуримтлал олгосон ба өссөн дүнгээр 28,491 хүүхэд хүүхдийн мөнгөн хуримтлалаа Төрийн санд байршуулан хуримтлуулсан байна. Тус журам нь 2023 оны 01 сараас хүчингүй болсон.

2.57. УИХ-аас хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нийгмийн халамжийн үйлчилгээ болгон зорилтод бүлэгт чиглүүлэх зорилгоор “Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай” хуулийг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр баталсан бөгөөд 2023 оны Төсвийн тухай хуульд хүүхдийн мөнгийг нийт хүүхдийн 91.0 хувьд 100.0 мянган төгрөгөөр үргэлжлүүлэн олгохоор тооцон 1,367.0 тэрбум төгрөг төсөвлөсөн. 2023 оны 6 дугаар сард 1,157,030 хүүхдэд өссөн дүнгээр 689.1 тэрбум төгрөгийг олгосон.

2.58. 2022 онд хүүхдийн мөнгөн тэтгэмжээ иргэнээс үл хамаарах шалтгаанаар авч чадаагүй 23,194 хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 4 дүгээр сард нөхөн олгосон. УИХ-ын 2023 оны 45 дугаар тогтоолоор хүсэлт гаргасан хүүхэд бүрд олгохоор шийдвэрлэж 2023 оны 1-6 сард хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамрагдаж чадаагүй хүүхдүүдийн нөхөн олголт болон үндсэн олголтоор 1,261,434 хүүхдэд мөнгөн тэтгэмжийг олгосон. ЗГ-ын 2023 оны 236 дугаар тогтоолоор хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам батлагдаж хүсэлт гаргасан хүүхэд бүрд олгож байна. 2023 оны 10 дугаар сарын байдлаар 1,296,577 хүүхдэд, өссөн дүнгээр 1,309.0 тэрбум төгрөгийг олгосон байна.

Дээрх байдлаас харахад 2022-2023 онд хүүхэд бүр "Хүүхэд хөгжлийн карт"-тай болсон байна гэсэн зорилт тооцоо судалгаа бүрэн хийгдээгүйгээс хэрэгжээгүй байна.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийгмийн халамжийн талаар тусгагдсан зарим зорилт арга хэмжээ бүрэн хэрэгжсэн ч шалгуур үзүүлэлтэд заасан хүрэх түвшиндээ ядуурлын түвшин, ажиллах хүчний оролцооны түвшин хүрэхгүй байх эрсдэлтэй байна

2.59. Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийгмийн халамжийн чиглэлээр “Нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчилнэ” гэсэн зорилгын хүрээнд дараах зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- *Нийгмийн халамж зорилтод бүлэгт хүрч, халамжийн үйлчилгээ ил, тод нээлттэй, чирэгдэлгүй болно.*
- *Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлнэ.*

Эдгээр зорилтын хэрэгжилт дараах байдалтай байна.

“Нийгмийн халамж зорилтод бүлэгт хүрч, халамжийн үйлчилгээ ил, тод нээлттэй, чирэгдэлгүй болно” зорилтын хүрээнд

Халамжийн үйлчилгээг ил тод, нээлттэй болгох зорилтын хэрэгжилтийг аудитын тайлангийн 2.5-2.7 хэсэгт дэлгэрэнгүй тусгасан болно.

2.60. Иргэд e-mongolia, ehalamj.mn цахим хуудас, төрийн үйлчилгээний цахим машин “ТҮЦ” машин, ebarimt аппликэйшнийг ашиглан нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах хүсэлтээ гаргах боломж бүрдсэн байна. Нийгмийн халамжийн үйл ажиллагааг цахим системд шилжүүлснээр иргэн материал бүрдүүлэхээс эхлэн халамж олголтын жагсаалт үүсгэн мэдээллийг банк руу илгээх хүртэл нийт дунджаар 15 өдөр зарцуулдаг байсныг 1-2 өдөр хүртэлх хугацаанд багасгах боломжтой болсон байна.

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

2.61. ХНХС-ын 2021 оны А/103 дугаар тоот тушаалаар “Хүнсний эрхийн бичиг олгох журмыг” шинэчлэн баталсан бөгөөд журамд зөвхөн гэрээт дэлгүүрүүдээр дамжуулах хүнсний таланоор үйлчлүүлэгчдэд үйлчилдэг байсныг болиулж, НӨАТ-ын баримт буюу и-баримт хэвлэдэг хүнсний дэлгүүр, зах, бөөний төвөөр үйлчлүүлэх боломжийг бүрдүүлсэн байна.

Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлэх зорилтын хүрээнд

2.62. Өрхийн амьжиргааны түвшнийг шууд илэрхийлэх, орлогын талаарх мэдээлэл, арга, аргачлал байхгүй үед түүнийг орлохуйц үзүүлэлтүүдийг ашиглан өрхийн амьжиргааны түвшний үнэлгээг хийж, түүний үр дүнг үндэслэн төрөөс үзүүлэх аливаа төрлийн нийгмийн тусламж, үйлчилгээнд хамруулах зорилтот бүлгийг тодорхойлох, өрхийн амьжиргааны түвшнээр эрэмбэлсэн өрхийн мэдээллийн нэгдсэн санг шинэчлэх зорилгоор ҮСХ-ны дарга, ХНХС-ын 2022 оны А/84, А/89 дүгээр хамтарсан тушаалаар “Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох хосолмол аргачлал” баталсан байна.

2.63. Энэхүү аргачлалын дагуу Монгол Улсын 2023 оны төсөвт хүүхдийн мөнгөн тэтгэмжийг амьжиргааны түвшинтэй уялдуулж нийт хүүхдийн 91 хувьд олгохоор болж 2023 оны 1-6 сарын хугацаанд 1'157'030 хүүхдэд 689,121.4 сая төгрөг олгосон байна.

2.64. Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нийт хүүхдийн 91 хувьд олгож үлдсэн 9 хувийг амьжиргааны түвшнээс дээш орлоготой өрх гэж тооцсон ч эдгээр 9 хувьд орсон өрхүүдээс хүүхдийн мөнгө авах хүсэлт, амьжиргааны түвшнийг ахин тооцуулах хүсэлтүүд удаа дараа ирсэн тул УИХ-ийн 2023 оны “Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн талаар авах зарим арга хэмжээн”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай 45 дугаар тогтоол, ЗГ-ын 2023 оны 236 дугаар тогтоолоор баталсан “Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам”-ын дагуу 2023 оны 7 дугаар сарын 1-ээс хүүхэд бүрд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг олгохоор болсон байна.

2.65. Үүнээс үзэхэд дээрх аргачлал нь хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээнд хамрагдах өрхийг бүрэн тодорхойлж чадаагүй байна.

2.66. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн “Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-д тусгасан зарим шалгуур үзүүлэлтийг хүрэх түвшинд чиглэсэн эсэхийг Үндэсний статистикийн хорооноос гаргасан статистик тоо мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 8: Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийгмийн халамжийн талаар тусгагдсан шалгуур үзүүлэлтийн үр дүн

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	2020 оны үр дүн	2021 оны үр дүн	2022 оны үр дүн	Хүрэх түвшин (2025 он)
1	Хүний хөгжлийн үзүүлэлт	индекс	0.74 ¹⁶	0.775	0.776	0.781	0.770
2	Хүн амын дундаж наслалт	жил	70.2		71.01	71.28	74
3	Дундаж ба түүнээс дээш давхаргын иргэдийн эзлэх хувь	хувь	71.6	72.2	-	-	80
4	Тэтгэвэр, тэтгэмжийн өсөлт		6				6
5	Ядуурлын түвшин	хувь	28.4	27.8	-	-	20
6	Ажиллах хүчний оролцооны түвшин	хувь	60.5	58.8	56.9	58.6	63

¹⁶ Бодлогын баримт бичигт суурь түвшнийг 2019 он гэж тусгасан ч тухайн онд энэ үзүүлэлт 0.76 байсан байна. Харин уг дүн 2014 оны үзүүлэлт байна.

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

7	Ажилгүйдлийн түвшин	хувь	10	7	7.8	6.7	7.8
---	---------------------	------	----	---	-----	-----	-----

Эх сурвалж Үндэсний статистикийн хороо

Дээрх үзүүлэлтээс харахад:

2.67. Хүний хөгжлийн үзүүлэлт болон ажилгүйдлийн түвшний үзүүлэлт 2022 оны байдлаар тодорхойлсон хүрэх түвшинд хүрсэн байна. Харин ажиллах хүчний оролцооны түвшний үзүүлэлт 2022 оны байдлаар суурь түвшний үзүүлэлтээс буурсан байна.

2.68. Дундаж ба түүнээс дээш давхаргын эзлэх хувийн үзүүлэлтийг Үндэсний статистикийн хороо 2 жил тутамд тооцоолон гаргадаг боловч 2022 оны үзүүлэлтийг тооцоолон гаргаагүй байна.

2.69. Тэтгэвэр тэтгэмжийн өсөлтийн шалгуур үзүүлэлтийн суурь түвшнийг 6, хүрэх түвшнийг 2025 онд 6 гэж заасан бөгөөд хэмжих нэгж, суурь түвшин тооцсон он тодорхойлоогүй байгаа нь шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшнийг бүрэн тооцох боломжгүй байна.

Нийгмийн халамжийн салбарын стратеги төлөвлөгөөнд тусгасан зорилт хуулийн шинэчлэл хийх зарим арга хэмжээ хэрэгжээгүйтэй холбоотойгоор бүрэн хэрэгжээгүй байна.

2.70. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөнд нийгмийн халамжийн чиглэлээр 3 зорилтын хүрээнд тодорхойлсон 9 арга хэмжээний зорилтод түвшинд чиглэсэн эсэхийг авч үзэхэд дараах байдалтай байна.

Зорилт 1	“Хүн ам, гэр бүлийн хөгжил, хамгааллын тогтолцоог бэхжүүлнэ” гэсэн зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.
-----------------	--

- *Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах,*
- *Дэд бүтцийн болон мэдээллийн хүртээмжийг сайжруулж, хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгмийн бүх харилцаанд бүрэн эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлэх*

2.71. **Нэг.** Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах арга хэмжээний хүрээнд:

2.72. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2022 оны 12 сарын байдлаар 4335 иргэн хамрагдсан байна. Уг ажилд ХЭДС-аас 9,245.3 сая төгрөгийг зарцуулж 1255 ажлын байр бий болсон байна. Хөтөлбөрийг арга хэмжээ тус бүрээр харуулбал:

- *Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 77 иргэн хамрагдаж, 116.0 сая төгрөг зарцуулж 19 иргэн ажилд зуучлагдсан байна.*
- *Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 872 иргэн хамрагдаж, 4,988.0 сая төгрөг зарцуулж, 937 ажлын байр бий болсон,*
- *Төрийн бус байгууллагад санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 30 төрийн бус байгууллага хамрагдаж, 280.0 сая төгрөг зарцуулж 62 ажлын байр бий болсон байна.*
- *Аж ахуй нэгжид санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 44 аж ахуй нэгж байгууллага хамрагдаж 1,550.0 сая төгрөг зарцуулж, 105 ажлын байр бий болсон.*
- *Борлуулалтын дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 31 борлуулалтын цэгийн 381 иргэн хамрагдаж 63.5 сая төгрөг зарцуулсан.*
- *Ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 132 иргэн хамрагдаж, 159.4 төгрөг зарцуулсан.*

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

- *Аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах арга хэмжээнд 2380 иргэн хамрагдаж 60.2 сая төгрөг зарцуулсан.*
- *Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах арга хэмжээнд 354 иргэн хамрагдаж, 111.9 сая төгрөг зарцуулж, 94 ажлын байр бий болсон.*
- *Ажил олгогчид дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 34 ажил олгогч хамрагдаж 38 иргэн ажлын байраар хангагдаж 182.7 төгрөгийн санхүүжилт тус тус гарсан байна.*
- *Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад үйл ажиллагаанд 1,733.6 сая төгрөг зарцуулсан байна.*

2.73. **Хоёр.** Дэд бүтцийн болон мэдээллийн хүртээмжийг сайжруулж, хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгмийн бүх харилцаанд бүрэн эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлэх арга хэмжээний хүрээнд:

Дэд бүтцийн хувьд:

2.74. Саадгүй байдал, хүртээмжийн үнэлгээ хийх нэгдсэн ажлын хэсгийг ХНХ-ын сайдын 2022 оны А/190 дугаар тушаал, Нийслэл дэх зарим төр, захиргааны барилга, байгууламжид холбогдох норм, дүрэм, стандартад нийцсэн эсэхэд үнэлгээ хийж, Хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгмийн үйлчилгээнд саадгүй хамрагдах боломжийг бий болгох талаар санал, дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий Дэд ажлын хэсгийг БХБЯ-ны ТНБД-ын 2022 оны А/169 дүгээр тушаал, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн зам, замын байгууламж, Нийтийн тээврийн үйлчилгээний саадгүй байдал, хүртээмжийн үнэлгээ хийх дэд ажлын хэсгийг ЗТХЯ-ны ТНБД-ын 2022 оны А/140 дүгээр тушаал, Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний хүртээмжийн үнэлгээ хийх дэд ажлын хэсгийг ЦХХХЯ-ны ТНБД-ын 2022 оны А/116 дугаар тушаалаар тус тус баталсан.

Дээрх ажлын хэсгүүдийн тайлан дүгнэлтээс харахад:

2.75. Барилга байгууламж хувьд: БХЯ, БШУЯ, БОАЖЯ, БХБЯ, ГХЯ, ЗТЯ, ЦХХХЯ, ХХААХҮЯ, СЯ, ХНХЯ, ХЗДХЯ, СЯ, УУХҮЯ, ЭЗХЯ, ЭМЯ, ЭХЯ /нийт 16/ яамны барилгад ажлын хэсэг төлөвлөгөөний дагуу 2022 оны 12 дугаар сарын 08-09-ний өдрүүдэд 53-н шалгуур үзүүлэлтээр үзлэг хийхэд шаардлага хангасан байгууллага байхгүй байна. Яамдын барилгын 56 хувь нь сайжруулах шаардлагатай, 44 хувь нь шаардлага хангаагүй, Нийслэлийн ЗДТГ болон 6 дүүргийн ЗДТГ-ын барилгыг 53 шалгуур үзүүлэлтийн дагуу үзлэг хийхэд барилга, байгууламж нэгдсэн дүгнэлтээр шаардлага хангахгүй байна.

2.76. Харин сайжруулах шаардлагатай 66 хувь, шаардлага хангаагүй 34 хувь гэсэн дүгнэлтийг гаргасан байна.

2.77. Авто зам, замын байгууламж, Нийтийн тээврийн хувьд: Сүхбаатар дүүргийн сонгогдсон нутаг дэвсгэрийн дагуу нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлж байгаа 118 автобусны 57 хувь нь үнэлгээний шалгуурт нийцсэн, 43 хувь нь нийцээгүй, Чингэлтэй дүүрэгт хамрагдсан 44 автобусны 62 хувь нь үнэлгээний шалгуурт нийцсэн байгаа нь нийтийн тээврийн автобусны 59.5 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ээлтэй орчин бүрдүүлэх нөхцөл хангагдсан байна.

2.78. Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн сонгогдсон 72 автобусны зогсоолын стандартын шаардлага хангасан буюу үнэлгээний үзүүлэлт 36.8 хувьтай байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэхэд нэн тэргүүнд автобусны зогсоолын стандартыг хангуулах, нийслэл хотын хэмжээнд бүх автобусны зогсоолын хашлага, налуу зам, гэрлэн дохио, замын тэмдэглэгээг шинэчлэх зайлшгүй шаардлага байна. Өвлийн халтиргаа, гулгаа, орчны нөлөөллөөс хамаарч эрсдэл өссөн үзүүлэлттэй байна.

2.79. Нийтийн тээврийн үйлчилгээ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмж, саадгүй байдлыг хангахгүй байна гэж ажлын хэсгээс дүгнэлт гарсан байна.

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

Мэдээллийн технологи, харилцаа холбооны хувьд:

Иргэдийн хамгийн их ашигладаг дараах 9 цахим хуудсанд үнэлгээ хийлээ. Үүнд:

1. ХБХХЕГ *gadpwd.gov.mn*
2. Худалдаа хөгжлийн банк *tdbm.mn*
3. Номин супермаркет *eshop.nomin.mn*
4. Е-баримт *ebarimt.mn*
5. Look TV *looktv.mn*
6. Ikon news *ikon.mn*
7. Unread news *unread.mn*
8. Халамжийн нэгдсэн систем *ehalamj.mn*
9. Өргөө кинотеатр *urguu.mn*

2.80. Үнэлгээнд хамрагдсан 9 цахим хуудас нь бүгд хүртээмжтэй байдлын шаардлагад нийцээгүй, шалгуур хангасан үзүүлэлт байхгүй байна.

2.81. Харааны бэрхшээлтэй иргэд цахим хуудас ашиглахад дараах нийтлэг бэрхшээлүүд тулгардаг байна.

- Дэлгэц унших программ нь энгийн хүний нүдээр харах дарааллаар уншигддаггүй. Алгасаж эсвэл өөр чиглэлд үсэрч уншдаг.
- Хэрэглэгч цахим хуудсанд зочлохдоо эхлээд гарчгуудыг уншин сонголтгоо хийж цааш үргэлжлүүлдэг. Гэвч гарчгуудын шилжих дараалал буруу байрласнаас дэлгэц унших программ гарчгуудыг бусад хэсгүүдтэй хольж уншин хэрэглэгчийг төөрөгдүүлдэг.
- Цахим хуудаснууд интерфэйс дизайны хувьд үзэмжтэй байлгахын тулд олон зургууд ашигладаг. Гэвч зургуудад тайлбар хийдэггүйгээс тухайн зураг ямар үүрэгтэй, ямар зураг гэдэг нь тодорхойгүй байдаг. Цахим хуудсанд зургийг үүрэггүйгээ үзэмж оруулах зориулалтаар оруулсан бол дэлгэц унших программ уншихгүйгээр идэвхгүй төлөвт хийх бөгөөд үүрэг зориулалттай зургийг программ унших тайлбартайгаар оруулах ёстой. (Тайлбар нь заавал харагдах албагүй)
- Зарим цахим хуудас хялбар ажиллагааны функцтэй байдаг ч энэ нь харааны бэрхшээлтэй хүн хайж олоход хүндрэлтэй. Жишээ нь Худалдаа хөгжлийн банкны цахим хуудсанд “Шуурхай шилжүүлэг” гэсэн функц байгаа боловч энэ функц дээр очихын тулд 14 элементийг уншиж өнгөрөх хэрэгтэй болдог байна.
- Ихэнх файл хэлбэрийн мэдээллүүд нь pdf өргөтгөлтэй байршсан байдаг ба үүнийг харааны бэрхшээлтэй хүн уншиж чаддаггүй.

2.82. Дээрх ажлын хэсгүүдийн тайлан дүгнэлтээс үзэхэд дэд бүтцийн болон мэдээллийн хүртээмж, хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгмийн бүх харилцаанд бүрэн дүүрэн эрх тэгш оролцох боломжийг бүрэн бүрдүүлээгүй байна.

Зорилт 2

“Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдлийг бууруулах замаар иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ” гэсэн зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

- Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, “Халамжаас хөдөлмөрт” хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх

2.83. Уг арга хэмжээний хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоолоор 2022-2023 онд хэрэгжих хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дараах 7 хөтөлбөр баталсан байна. Үүнд:

- Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр,
- Аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр,

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

- *Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр,*
- *Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр,*
- *Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр,*
- *Ногоон ажлын байр хөтөлбөр,*
- *Эмзэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр.*

2.84. Эдгээр хөтөлбөрүүдээс “Халамжаас хөдөлмөрт” зорилтын хүрээнд ажил олоход хүндрэлтэй иргэдэд чиглэсэн Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.

2.85. Тус хөтөлбөрүүдэд 2022 онд нийт 20445 иргэн хамрагдаж, 4134 иргэн ажлын байраар хангагдаж, 10.9 тэрбум төгрөгийг ХЭДС-аас зарцуулсан байна. Халамжаас хөдөлмөрт зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хэрэгжилтийг харуулбал:

Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийн хувьд:

2.86. Ажил олоход хүндрэлтэй иргэн, ялангуяа нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны бөгөөд хөдөлмөрийн чадвартай гишүүнийг хөдөлмөрт бэлтгэж, ажлын байраар хангах, ажил олгогчдын оролцоог хангахад хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон байна.

2.87. Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийн хэрэгжилтийг 2022 оны жилийн эцсийн байдлаар 16018 иргэн хамрагдаж, 2875 иргэн ажлын байраар хангагдаж, 1,383.7 сая төгрөгийг зарцуулсан байна. Хөтөлбөрийг арга хэмжээ тус бүрээр нь авч үзвэл,

- *Ажлын байрны харилцаа, сэтгэл зүйн сургалтад 6894 иргэн хамрагдаж, 578 иргэн ажлын байраар хангагдаж, 205.6 сая төгрөг,*
- *Ажилд зуучлах уулзалтад бэлтгэхэд 5750 хүн хамрагдаж, 1193 хүн ажлын байраар хангагдаж, 259.0 сая төгрөг,*
- *Танхимын сургалтад 2996 хүн хамрагдаж, 751 хүн ажлын байраар хангагдаж, 802.8 сая төгрөг,*
- *Үйлдвэр дээрх сургалтад 245 хүн хамрагдаж, 220 хүн ажлын байраар хангагдаж, 103.9 сая төгрөг,*
- *Нийгмийн хариуцлагатай ажил олгогчийг дэмжих арга хэмжээнд 133 хүн хамрагдаж, 133 иргэн ажлын байраар хангагдаж 12.4 сая төгрөгийг тус тус ХЭДС-аас зарцуулсан байна.*

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хувьд:

2.88. Хөтөлбөрийн зорилго нь “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөр эрхлэх, хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, тэдгээрийн онцлог хэрэгцээнд нь нийцсэн тусгайлсан ажлын байр бий болгох, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангахад ажил олгогчийг дэмжих” гэж тодорхойлогдсон байна.

2.89. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2022 оны жилийн эцсийн байдлаар 4427 иргэн хамрагдаж ХЭДС-аас 9,493.9 сая төгрөгийг зарцуулж, 1259 иргэн ажлын байраар хангагдсан байна. Хөтөлбөрийг арга хэмжээ тус бүрээр харуулбал,

- *Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 77 иргэн хамрагдаж, 19 иргэн ажилд зуучлагдаж, 116.0 сая төгрөг,*
- *Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 872 иргэн хамрагдаж, 937 иргэн ажлын байраар хангагдаж, 4,988.0 сая төгрөг,*

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

- Төрийн бус байгууллагад санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 30 төрийн бус байгууллага, 62 иргэн хамрагдаж, 62 иргэн ажлын байраар хангагдаж, 575.0 сая төгрөг,
- Аж ахуй нэгжид санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 44 аж ахуй нэгж байгууллага хамрагдаж, 105 иргэн хамрагдаж, 105 иргэн ажлын байраар хангагдаж, 1,550.0 сая төгрөг,
- Борлуулалтын дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 381 иргэн хамрагдаж, 63.5 сая төгрөг,
- Ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 132 иргэн хамрагдаж, 159.3 сая төгрөг,
- Аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах арга хэмжээнд 2380 иргэн хамрагдаж, 60.2 сая төгрөг,
- Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах арга хэмжээнд 384 иргэн хамрагдаж, 102 иргэн ажлын байраар хангагдаж, 129.1 сая төгрөг,
- Ажил олгогчид дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 34 ажил олгогч хамрагдаж, 34 иргэн хамрагдаж, 182.7 сая төгрөг,
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад үйл ажиллагаанд 1,733.6 сая төгрөгийг ХЭДС-аас тус тус зарцуулсан байна.

Зорилт 3

“Зорилтот иргэн, даатгуулагчид нийгмийн хамгааллын үйлчилгээг хүргэж, нийгмийн баталгаагаар хангана” гэсэн зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

- Зорилтот өрх, иргэдийн амьдралын нөхцөл, амьжиргааны түвшнийг дээшлүүлэх оновчтой арга зам бүхий халамжийн бодлогын шинэчлэл хийх,
- Нийгмийн халамжийн багц хуулийг хэрэгжүүлэх журам, дүрэм заавар, аргачлалыг боловсронгуй болгох, шинэчлэх,
- Зорилтот бүлгийг тодорхойлох аргачлалыг боловсронгуй болгох, шинэчлэх, аргачлалын дагуу амьжиргааны түвшнийг тодорхойлох судалгааг зохион байгуулах, мэдээллийн сан бүрдүүлэхэд нэгдсэн удирдлагаар, арга зүйгээр хангах,
- Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг амьжиргааны доод түвшинтэй уялдуулан жил бүр нэмэгдүүлэх,
- Нийгмийн даатгал, нийгмийн халамжийн хүний нөөцийг чадавхжуулах сургалтын платформ, хөтөлбөрийг боловсруулж, салбарын ажилтан, алба хаагчид, гэрээт төрийн бус байгууллагыг чадавхжуулах,
- Нийгмийн халамжийн хууль тогтоомжийн талаар иргэд, олон нийтийн ойлголт, хандлагыг сайжруулах зорилгоор мэдээлэл, сурталчилгааны ажлын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх.

2.90. **Нэг.** Зорилтот өрх, иргэдийн амьдралын нөхцөл, амьжиргааны түвшнийг дээшлүүлэх оновчтой арга зам бүхий халамжийн бодлогын шинэчлэл хийх арга хэмжээний хувьд:

2.91. Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн нэр төрөл, хамрах хүрээг оновчтой болгох, давхардлыг арилгаж халамжийн туслалцаа хамгийн их шаардлагатай зорилтот бүлэгт тэтгэвэр, тэтгэмжийг чиглүүлэх үндсэн зарчмыг баримтлан Нийгмийн халамжийн багц хуулийн шинэчлэлийг боловсруулсан. Үзэл баримтлалыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дах заалтын дагуу батлуулсан ч 2022 оны 8 дугаар сард Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбоотой Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг ЗГХЭГ-ын 2022 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн ХЭГ/1996 дугаар албан бичгээр буцаан ирүүлсэн. Үүнтэй холбогдуулан Нийгмийн халамжийн тухай

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөл, тандан судалгааг шинэчлэн ажиллаж байна. 2023 оны 10 сарын байдлаар хууль УИХ-аар батлагдаагүй байна.

2.92. **Хоёр.** Зорилтот бүлгийг тодорхойлох аргачлалыг боловсронгуй болгох, шинэчлэх, аргачлалын дагуу амьжиргааны түвшнийг тодорхойлох судалгааг зохион байгуулах, мэдээллийн сан бүрдүүлэхэд нэгдсэн удирдлагаар, арга зүйгээр хангах арга хэмжээний хувьд:

2.93. Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох аргачлалыг 2018 оны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны мэдээлэл болон холбогдох төрийн мэдээллийн санг ашиглаж, уялдуулан загварын үнэлгээ, тооцооллыг олон хувилбараар үнэлж, гүйцэтгэлийг сайжруулж буй хувилбаруудыг нэгтгэн, шинэ загварыг боловсруулан загварын үнэн бодит байдлыг шалгаж, эцсийн загварын төслийг боловсруулсан судалгааны үр дүнд үндэслэн ҮСХ-ны дарга, ХНХС-ын 2022 оны А/84, А/89 хамтарсан тушаалаар “Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох хосолмол аргачлал” батлагдсан.

2.94. **Гурав.** Нийгмийн даатгал, нийгмийн халамжийн хүний нөөцийг чадавхжуулах сургалтын платформ, хөтөлбөрийг боловсруулж, салбарын ажилтан, албан хаагчид, гэрээт төрийн бус байгууллагыг чадавхжуулах арга хэмжээний хувьд:

2.95. Сургалтын модуль хөтөлбөрийг боловсруулж, цахим хэлбэрт оруулан платформд байршуулах байгууллагыг сонгох ажлын даалгаврыг боловсруулах, байгууллагыг сонгож хамтран ажилласан байхаар шалгуур үзүүлэлт хүрэх үр дүнгээ тодорхойлон ажлын даалгавар боловсруулсан ч гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажил хийгдээгүй байна.

2.96. Эдгээр стратеги арга замын хэрэгжилтийг 2022 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтэд 82.5 хувь буюу арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ авч эхэлснээр гол үр дүн гарч эхэлсэн байна.

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

БҮЛЭГ 3. Халамжийн сангийн хөрөнгийг зорилтод бүлгээс илүү нийтийг хамарсан шинжтэй үйлчилгээнд зарцуулж байна


“Нийгмийн халамж” гэж тодорхойлсон үйл ажиллагаанд нийцээгүй, нийтийг хамарсан шинжтэй үйлчилгээнд халамжийн сангийн 80 орчим хувийг зарцуулж байна.

3.1. Нийгмийн халамжийн чиглэлээр 6 хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан 40 гаруй журмын хүрээнд 75 нэр төрлийн үйлчилгээ үзүүлэхээр зохицуулсан байна. Эдгээр үйлчилгээнээс дараах 3 үйлчилгээг нарийвчлан зохицуулсан журам, зааваргүй, батлагдсан төсөвгүйгээс нийгмийн халамж авагч иргэдэд үзүүлдэггүй байна. Үүнд:

- Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэний тэтгэмж,
- Боловсролыг дэмжих үйлчилгээ,
- Аарцаг эрхтний үйл ажиллагаа алдагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүнд эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр зайлшгүй шаардлагатай асаргаа сувилгаа, ариун цэвэр, эрүүл ахуйн материалын дэмжлэг үзүүлэх.

Энэ 3 үйлчилгээнээс бусад 72¹⁷ үйлчилгээг нийгмийн халамж авагч иргэдэд үзүүлж байна.

3.2. Нийгмийн халамжийн тухай хуулийн 5 дугаар зүйлд **“Нийгмийн халамжийн үйл ажиллагаа”**-ны төрлийг дараах байдлаар тодорхойлсон байна.



3.3. Дээрх байдлаас харахад нийгмийн халамжийн үйл ажиллагаанд хамаарахгүй 39 үйлчилгээг бие даасан хууль, журмын хүрээнд нийгмийн халамж авагч иргэнд үзүүлж байна.

3.4. Нөгөө талаар Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “Нийгмийн халамж”-ийг дараах байдлаар тодорхойлсон байна.

Нийгмийн халамж

Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай


¹⁷ Энэ 72 үйлчилгээ нь нийт 399 нэр төрлийн үйлчилгээнд хуваагдсан байна. Уг нэгж үйлчилгээ бүрээр код үүсгэн бүртгэсэн байна.

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа.

3.5. Нийгмийн халамжийн чиглэлээр үзүүлж байгаа 72 үйлчилгээг энэ тодорхойлолттой нийцэж буй эсэхийг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл 2: Нийгмийн халамжийн үйлчилгээ “Нийгмийн халамж” тодорхойлолтод нийцсэн байдал



Эх сурвалж: Аудиторын тооцоолол /Дэлгэрэнгүйг хавсралт 4-өөс харна уу/

3.6. Эдгээр нөхцөл байдлаас харахад олон нийтийг хамарсан болон тодорхой бүлэгт чиглэсэн үйлчилгээг хууль, журмаар тодорхойлон нийгмийн халамжид хамаатуулж, Нийгмийн халамжийн тухай хуульд заасан “НИЙГМИЙН ХАЛАМЖ”, “НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА”-ны талаарх ойлголтыг алдагдуулсан байна.

3.7. “Нийгмийн халамж”-ийн талаар олон улсын байгууллагууд дараах байдлаар тодорхойлсон байна. Тухайлбал:

Их Британы Олон Улсын Хөгжлийн Яам “Нийгмийн халамж” гэж ядуурал ба эмзэг байдлыг үндэслэн олон нийтээс тодорхойлсон бүлгийнхэнд тэднээс хувь шимтгэл шаардахгүйгээр буцалтгүй олгож байгаа тусламжийг хэлнэ.

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага “Нийгмийн халамж” гэж орлого багатай хүмүүст үзүүлэх татвараас санхүүжигдэх тэтгэмж, тусламжийг хэлнэ.

3.8. Олон улсын байгууллагаас тодорхойлсон “Нийгмийн халамж”-ийн талаарх дээрх ойлголтоос харахад манай улсын нийгмийн халамжийн чиглэлээр үзүүлж байгаа зарим үйлчилгээ нь нийгмийн халамжид хамаарахгүй байна.

3.9. Нөгөө талаар нийгмийн халамжийн чиглэлээр үзүүлж байгаа үйлчилгээнүүдийг зохицуулсан хууль, журмууд нь хоорондоо уялдаа муутай, хууль доторх зүйл, заалт нь логик уялдаагүй байна. Жишээ дурдвал:

“Эхийн алдар” одон	Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасан нийгмийн халамжийн тэтгэмжид хамааруулсан нь тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан “Нийгмийн халамж” гэсэн тодорхойлолттой нийцээгүй.
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасан нийгмийн халамжийн тэтгэмжид хамааруулсан нь тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан “Нийгмийн халамж” гэсэн тодорхойлолттой нийцээгүй.

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

Ахмад настны тухай хууль болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасан “Нийгмийн халамж” гэсэн тодорхойлолтод нийцэх үйлчилгээнүүд нь Нийгмийн халамжийн тухай хуультай уялдаагүй.

3.10. Энэ нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1¹⁸, 14 дүгээр зүйлийн 14.2.4¹⁹, 17 дугаар зүйлийн 17.2.1²⁰, 17.2.2²¹-д заасан шаардлагуудыг тус тус хангаагүй байна.

3.11. Нийгмийн халамжийн чиглэлээр үзүүлж буй үйлчилгээнүүдийг нийтэд нь нийгмийн халамжид хамаатуулж байгаа нь нэг талаар “Халамжийн сан”-тай холбоотой байна. Өөрөөр хэлбэл үйлчилгээнүүдэд шаардлагатай хөрөнгийг халамжийн санд төвлөрүүлэн зарцуулж байна.

3.12. Халамжийн сангаас нийгмийн халамжийн чиглэлээр үзүүлж буй үйлчилгээнүүдэд олгосон санхүүжилтийг сүүлийн 5 жилээр харуулбал:

Хүснэгт 9: Халамжийн сангийн зарцуулалт /сая хүн (давхардсан тоогоор), тэрбум төгрөг/

Үйлчилгээний ерөнхий ангилал	2019		2020		2021		2022		2023.06	
	Хүний тоо	Үнийн дүн	Хүний тоо	Үнийн дүн	Хүний тоо	Үнийн дүн	Хүний тоо	Үнийн дүн	Хүний тоо	Үнийн дүн
НИЙТ ДҮН	2.46	671.1	2.6	1,586.9	2.55	1,855.3	2.61	2,000.5	2.26	968.6
Нийгмийн халамжийн тэтгэвэр	0.06	111.6	0.06	162.9	0.07	184.4	0.06	182.9	0.06	92.4
Нийгмийн халамжийн тэтгэмж	1.3	336.8	1.5	1,182.2	1.58	1,471.4	1.63	1,623.0	1.5	776.0
Асаргааны тэтгэмж	0.06	47.7	0.06	58.5	0.06	59.4	0.06	59.39	0.06	30.29
Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	0.27	59.5	0.28	70.7	0.29	75.7	0.3	78.67	0.3	56.61
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	1.0	229.6	1.18	1,053.0	1.22	1,336.3	1.26	1,484.9 ²²	1.15	689.1
Нийгмийн халамжийн үйлчилгээ	0.01	1.8	0.01	2.02	0.0	2.3	0.01	3.07	0.0	1.5
Олон нийтийн оролцоонд	0.01	1.7	0.01	1.74	0.0	2.1	0.01	2.59	0.0	1.5

¹⁸ Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуульд нийцэх эсэхийг судлах

¹⁹ хууль тогтоомжийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

²⁰ хууль тогтоомжийн төсөл, эсхүл түүний зарим зүйл, заалтын зохицуулалтын практикт хэрэгжих боломж, харилцан уялдаа зэргийг тооцож шинжилгээ хийх

²¹ хууль тогтоомжийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах

²² Санхүүжилтийг Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 9¹ дүгээр зүйлд заасны дагуу ирээдүйн өв сангаас гаргасан.

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

түшиглэсэн халамжийн үйлчилгээ										
Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ	0.0	0.1	0.0	0.28	0.0	0.2	0.0	0.48	-	-
Нийгмийн хөгжлийн үйлчилгээ	0.2	35.8	0.2	55.4	0.2	30.96	0.12	19.9	0.1	7.9
Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	0.2	35.8	0.2	55.4	0.2	30.96	0.12	19.9	0.1	7.9
Эцэг, эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт олгох тэтгэмж	0.3	115.4	0.3	116.3	0.3	114.6	0.3	108.7	0.2	54.1
Ахмад настны дэмжлэг, хүндэтгэл	0.4	52.2	0.4	51.2	0.37	40.96	0.4	51.04	0.34	35.93
Ахмад настанд олгох дэмжлэг, хөнгөлөлт	0.1	28.5	0.2	26.8	0.09	15.13	0.1	23.69	0.05	8.19
Ахмад настанд үзүүлэх хүндэтгэл, насны хишиг	0.3	23.7	0.2	24.4	0.28	25.83	0.3	27.35	0.29	27.74
Алдар цолтон ахмад настанд олгох нэмэгдэл, хөнгөлөлт	0.0	5.1	0.0	5.1	0.0	0.4	0.0	0.68	0.0	-
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлт	0.06	11.5	0.05	10.8	0.04	9.29	0.05	10.1	0.01	-
Тайгад амьдардаг цаатан иргэнд олгох тэтгэмж	0.0	0.6	0.0	0.7	0.0	0.8	0.0	0.8	0.0	0.5

Эх сурвалж: ХХҮЕГ /Дэлгэрэнгүйг хавсралт 5-аас харна уу/

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

3.13. Уг мэдээллээс харахад жилд дунджаар 2.49 сая (давхардсан тоогоор) иргэнд 1.4 их наяд төгрөгийг нийгмийн халамжийн чиглэлээр олгож байна. Мөн нийгмийн халамжийн сангийн төсөвт жилээс жилд өссөн байна.

3.14. Халамжийн сангаас олгосон хөрөнгийг “Нийгмийн халамж”-ийн тодорхойлолттой нийцсэн болон нийцээгүй үйлчилгээнд хуваарилан харуулбал:

Хүснэгт 10: Халамжийн сангийн зарцуулалт /сая хүн, тэрбум төгрөг/

Ангилал	2019		2020		2021		2022		2023.06	
	Хүний тоо	Үнийн дүн	Хүний тоо	Үнийн дүн	Хүний тоо	Үнийн дүн	Хүний тоо	Үнийн дүн	Хүний тоо	Үнийн дүн
Нийгмийн халамжийн тодорхойлолттой нийцсэн үйлчилгээ	0.61	257.7	0.6	348.8	0.48	341.8	0.47	337.8	0.33	164.3
Нийт дүнд эзлэх хувь	25%	38%	23%	22%	19%	18%	18%	17%	15%	17%
Нийгмийн халамжийн тодорхойлолттой нийцээгүй үйлчилгээ	1.85	413.2	2.0	1,238.1	2.07	1,513.5	0.88	1,662.7	1.93	804.3
Нийт дүнд эзлэх хувь	75%	62%	77%	78%	81%	82%	82%	83%	85%	83%
Нийт дүнд ихэнх хувийг эзэлж байгаа үйлчилгээнүүд										
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	41%	34%	45%	66%	48%	72%	48%	74%	51%	71%
“Эхийн алдар” одон	9%	4%	9%	2%	9%	2%	9%	2%	11%	3%

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

3.15. Энэ үзүүлэлт нь Халамжийн сангийн хөрөнгө нийгмийн халамж шаардлагатай иргэдээс илүү нийтийг хамарсан тэтгэмж, тусламж, дэмжлэг, хөнгөлөлт, урамшуулалд зарцуулагдаж байгааг харуулж байна. Үүнээс “Хүүхдийн мөнгөн тэтгэмж”, “Эхийн алдар” одонд Халамжийн сангийн дунджаар 66 хувийг зарцуулж байна.

634,818 иргэн	Нийгмийн халамжийн чиглэлээрх үйлчилгээнд (Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг оруулаагүй) давхардалгүйгээр нийт 634.8 ²³ мянган иргэн хамрагдаж байна.
----------------------	---

3.16. Нийгмийн халамжийн чиглэлээр үзүүлж байгаа үйлчилгээнд нийт 1,766,125 иргэн (2023 оны 3 дугаар улирлын байдлаар) хамрагдаж байгаагаас 1,131,307 иргэн хүүхдийн мөнгөн тэтгэмж, үлдсэн 634,818 иргэн нь бусад үйлчилгээнд хамрагдаж байна.

3.17. Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хадгаламж хэлбэрээр хадгалдаг болон эцэг, эхийн харилцах дансаар дамжуулан зарцуулдаг хүүхдийн тоог зарим банкны мэдээллээр харуулбал:

Хүснэгт 11: Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн зарцуулалт /2023 оны 10 дугаар сарын байдлаар/

№	Банк	Хүүхдийн тоо	Хадгаламж хэлбэрээр байршуулдаг хүүхдийн тоо	Харилцах дансаар дамжуулан зарцуулдаг хүүхдийн тоо

²³ 2023 оны 3 дугаар улирлын байдлаар

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

1	Худалдаа хөгжлийн банк	38,851	23,778	15,073
2	ХААН банк	474,382	65,504	408,878
3	Төрийн банк	586,183	132,571	415,411
4	Голомт банк	26,100	20,949	5,151
5	Хас банк	158,863	98,842	60,021
Нийт		1,284,379	341,644	904,534

Эх сурвалж: ХХҮЕГ

3.18. Энэ үзүүлэлтээс харахад хүүхдийн мөнгөн тэтгэмжийн дийлэнх нь шууд зарцуулагдаж байна.

3.19. Хүүхдийн мөнгөн тэтгэмжээс бусад үйлчилгээ авч байгаа иргэдийн нийт хүн амын тоонд эзлэх хувийг тооцон ядуурлын хамралтын хүрээтэй харьцуулбал:

Хүснэгт 12: Нийгмийн халамж авагч иргэдийн нийт хүн амд эзлэх хувь

Он	2018	2020	2022	2023.III
Нийт хүн амын тоо	3,238,479	3,357,542	3,457,548	гараагүй
Халамж авагч иргэний тоо	655,400	686,488	710,423	634,818
Халамж авагч иргэний нийт хүн амд эзлэх хувь	20.2%	20.4%	20.5%	
Ядуурлын хамралтын хүрээ	28.4%	27.8%	гараагүй	гараагүй

Нийт хүн амд нийгмийн халамж авагч иргэдийн эзлэх хувь ядуурлын хамралтын хүрээнээс бага байгаа нь нийгмийн халамж шаардлагатай зорилгод бүлэг орхигдсон байх магадлалтай байна.

Эх сурвалж: 1212.тп, ХХҮЕГ

3.20. Нийгмийн халамж авагч иргэдийн тооноос “Нийгмийн халамж” гэсэн тодорхойлолтод нийцээгүй үйлчилгээ авсан иргэдийг хасаж тооцвол нийгмийн халамж шаардлагатай зорилтод бүлэг орхигдсон байх магадлал нэмэгдэхээр байна.

Нийгмийн халамжийн чиглэлээр үзүүлж байгаа үйлчилгээнээс нэг иргэн хэдэн төрлийн үйлчилгээнд хамрагдсаныг шинжлэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 13: Нэг иргэний авсан үйлчилгээний тоо /2023 оны 10 дугаар сарын байдлаар/

Нэг иргэний авсан үйлчилгээний тоо	Иргэний тоо
19	1
18	5
17	1
16	6
15	15
14	22
13	53
12	81
11	182
10	339
9	640
8	1,236
7	2,770
6	6,438
5	13,789
4	32,236
3	84,444
2	213,861
1	1,410,006

Энэ үзүүлэлтээс харахад нэг иргэн хамгийн их нь 19 үйлчилгээ авсан байна.

Олон үйлчилгээ авч байгаа иргэн нь ихэвчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон ахмад настан бөгөөд протез, ортопедын хэрэгсэл, тусгай хэрэгсэл авсан байна.

Нэг иргэн олон үйлчилгээ авахад хориглосон зохицуулалт байхгүй байна.

Тайлбар: Нийгмийн халамжийн чиглэлээр үзүүлж байгаа 72 үйлчилгээнд нийт 399 нэр төрлийн нэгж үйлчилгээ хамаарч байгаа бөгөөд энэ 399 үйлчилгээнээс иргэд 1-19 нэр төрлийн үйлчилгээ авсан.

Эх сурвалж: ХХҮЕГ

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

3.21. Нийгмийн халамжийн чиглэлээр үзүүлж байгаа үйлчилгээнүүдийг иргэдэд ил тод, нээлттэй, чирэгдэлгүй хүргэх зорилгоор цахим хэлбэрт шилжүүлэн ажиллаж байна. Уг ажлын хүрээнд 72 үйлчилгээний 67 нь цахим хэлбэртэй болсон байна. Дараах цахим системүүдийг ашиглаж байна. Үүнд:

- www.ehalamj.mn халамжийн нэгдсэн системийг 2020 оноос эхлэн нэвтрүүлж нийт 65 үйлчилгээг хамруулсан,
- www.heb2017.hudulmur-halamj.gov.mn системийг 2017 оноос эхлэн нэвтрүүлж эрүүл мэндийг дэмжих болон хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээг үзүүлж байна.

3.22. Энэ 2 системээр үзүүлж байгаа 67 үйлчилгээнээс 13 нь бүрэн цахим болсон, бусад үйлчилгээ нь шаардлагатай баримт материалыг цахим хэлбэрт шилжүүлэн хавсаргах зэрэг ажиллагаатай холбоотой цаас болон цахим хосолсон хэлбэртэй байна. Тодруулбал:

Тухайн үйлчилгээтэй холбоотой төрийн байгууллагаас гарах тодорхойлолт, зөвлөлийн шийдвэр, мэргэжлийн хүний дүгнэлт зэрэг нь цаасан хэлбэртэй байна.

Үйлчилгээг цахим хэлбэртэй болгосноор:

- Арилжааны банканд төлөх үйлчилгээний хураамж, нийгмийн халамжийн дэвтэр, хувийн хэрэг, маягт хэвлэх зэрэг зардлыг хэмнэсэн,
- Иргэдийн төрийн үйлчилгээг авахад зарцуулдаг хугацааг хэмнэсэн,
- Иргэн банк харгалзахгүйгээр өөрийн нэрийн дансаар дамжуулан нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн мөнгөө авах боломжтой болсон,
- Өөрийн гаргасан өргөдөл, хүсэлтийнхээ шийдвэрлэлтийн явцад хяналт тавих боломжтой болсон,
- Иргэн үйлчилгээнд хүсэлт гаргах 5 /ehalamj.mn, ebarimt.mn, emongolia.mn, ТҮЦ машин, сум хорооны ажилтанд хандах/ боломжоос өөрт тохирохыг нь сонгох боломжтой болсноор иргэний сонголтыг өргөжүүлсэн зэрэг давуу талууд бий болсон байна.

3.23. Иргэд нийгмийн халамжийн чиглэлээр үзүүлж байгаа үйлчилгээг ямар хэлбэрээр авч байгааг харуулбал:

Хүснэгт 14: Иргэдийн үйлчилгээ авч буй хэлбэр

Он	Үйлчилгээ авсан иргэдийн тоо		
	Халамжийн байгууллагад очиж үйлчилгээ авсан	цахимаар	нийт
2023	605,590	79,896	685,486
2022	537,784	72,969	610,753

Энэ үзүүлэлтээс харахад нийгмийн халамжийн чиглэлээр үйлчилгээ авч байгаа иргэдийн 88% нь нийгмийн халамжийн байгууллагад очиж үйлчилгээ авч байна.

Эх сурвалж: ХХҮЕГ

3.24. Иргэдийн дийлэнх нь нийгмийн халамжийн байгууллагад очиж үйлчилгээ авч байгаад дараах зүйлс нөлөөлж байна. Тухайлбал:

- Иргэдийн цахим орчинд ажиллах ойлголт мэдлэг дутмаг,
- Интернет, ухаалаг утасны хэрэглээ хязгаарлагдмал, байхгүй зэрэг нөлөөлж байна.

Халамж

Хөдөлмөр

3.25. Нийгмийн халамж авагч иргэний мэдээллийг нийгмийн даатгалын мэдээлэлтэй тулган шинжилгээ хийхэд нийт 202,238 нийгмийн халамж авдаг иргэн нийгмийн даатгалд бүртгэлтэй байна. Үүнээс албан журмаар даатгуулсан 171,085 иргэн, сайн дураар даатгуулсан 38,576 иргэн байна.

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

3.26. Эдгээр иргэд нь нийгмийн халамжийн чиглэлээр үзүүлж байгаа нийт 246 үйлчилгээнд давхардсан тоогоор 296,420 удаа хамрагдсан байна. Үүнээс хамгийн их хамрагдсан 5 үйлчилгээг харуулбал:

Хүснэгт 15: Нийгмийн даатгалд бүртгэлтэй иргэдийн хамгийн их авсан нийгмийн халамжийн үйлчилгээ

№	Үйлчилгээний төрөл	Үйлчилгээ авсан иргэдийн тоо
1	Хүүхдийн мөнгөн тэтгэмж	84,028
2	“Эхийн алдар” 2-р зэргийн одон	60,577
3	0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж	44,253
4	Хиймэл шүд	12,852
5	Ахмад настныг асарч байгаа иргэнд олгох тэтгэмж	10,260
	Нийт	211,970

Энэ 5 үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо нийт хамрагдалтын 71.5%-г эзэлж байна.

Үүнээс ахмад настныг асарч байгаа иргэд хөдөлмөр эрхэлж байгаа нь тус үйлчилгээг бүрэн үзүүлдэг гэдэгт эргэлзээ төрүүлэхүйц байна.

Энэ талаар нарийвчилсан зохицуулалтгүй байна.

Эх сурвалж: НДЕГ, ХХҮЕГ

3.27. Нийгмийн даатгалд бүртгэлтэй иргэдийн авч байгаа үйлчилгээнд “Хүнсний бүтээгдэхүүн худалдан авах эрхийн бичиг олгох” үйлчилгээ байхгүй байна.

3.28. Нийгмийн халамж нь иргэний ажил эрхлэх сонирхлыг бууруулахад нөлөө үзүүлдэг эсэхийг тодруулахад холбогдох байгууллагуудад уг асуудлаар судалгаа, дүн шинжилгээ хийгдээгүй байна.

Харин Удирдлагын академи болон Санхүү, эдийн засгийн их сургуулийн судалгааны багууд дараах судалгааг хийж дүгнэсэн байна.

- Удирдлагын академийн судалгааны баг 2022 онд “**Нийгмийн халамжийн бодлогын хөдөлмөр эрхлэлтэд үзүүлж буй нөлөө**” сэдэвт судалгаа хийсэн байна. Судалгааны ажлын үр дүнд:

“Нийгмийн халамжил хамрагдсанаар хөдөлмөрөөс хойш суух байдал төдийлөн ажиглагдсангүй, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ бага, хүрэлцээт байдал хангалтгүй тул нийгмийн халамжид хамрагдаж буй иргэд албан, албан бус салбарт ажил хөдөлмөр эрхлэх явдал түгээмэл байсан, гэвч хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлж болох хэдэн арван шалтгааны зөвхөн нэг нь нийгмийн халамж болохыг судалгааны дүн харуулсан” гэж дүгнэсэн байна.

- Санхүү, эдийн засгийн их сургуулийн санхүү, удирдлагын тэнхимийн багш, оюутнуудын 2023 онд нийт 1006 иргэнийг хамруулан хийсэн “**Иргэдэд олгох мөнгөн шилжүүлэг иргэдийн хөдөлмөр эрхлэх сонирхолд нөлөөлөх нь**” сэдэвт судалгааны ажлын үр дүнд:

“Бусад хүчин зүйл тогтмол байхад уг тэтгэмжүүдийг авдаг байх үеийн ажил эрхлэх сонирхлын өсөлт бууралтыг судлахад хүнсний тэтгэмж авдаг үед 1.912%, нөхцөлт мөнгөн тэтгэмж авдаг үед 0.74%, өрх толгойлсон эцэг эхийн тэтгэмж авдаг үед 0.95%-аар ажил эрхлэх сонирхол буурдаг гэх үр дүн гарсан нь мөн халамж хөдөлмөр эрхлэх сонирхолд нөлөөлдөг болохыг харуулж байна” гэсэн дүгнэлтэд хүрсэн байна.

3.29. Энэ нь нийгмийн халамж иргэний хөдөлмөр эрхлэх сонирхлыг тодорхой хэмжээнд бууруулж байж болзошгүйг илэрхийлж байгаа тул нэгдсэн судалгаа, шинжилгээ хийж үр дүнг тодорхойлон шийдэл гаргах шаардлагатай байна.

3.30. Нийгмийн халамжийн тухай хуульд “Нийгмийн халамж нь нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилготой” гэж тодорхойлсонтой холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

тогтоосон нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмж, хүнс тэжээлийн дэмжлэгийн хэмжээг ядуурлын шугамтай²⁴ харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 16: Нийгмийн халамжийн тарифын хэмжээ ядуурлын шугамын харьцаа /төгрөг/

Үзүүлэлт	2018	2020	2023
Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээ	174,000	288,000	325,000
Ядуурлын шугам	166,580	184,747	гараагүй
Зөрүү	7,420	103,253	-
Асаргааны тэтгэмж	76,000	84,500	275,000
Ядуурлын шугам	166,580	184,747	гараагүй
Зөрүү	(90,580)	(100,247)	-
Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэл насны хүүхэд	174,000	288,000	325,000
Ядуурлын шугам	166,580	184,747	гараагүй
Зөрүү	7,420	103,253	-
Байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш настай иргэн	20,000	20,000	20,000
Ядуурлын шугам	166,580	184,747	гараагүй
Зөрүү	(146,580)	(164,747)	-
Хүнс тэжээлийн дэмжлэг /том хүн/	16,000	16,000	16,000
Ядуурлын шугам	166,580	184,747	гараагүй
Зөрүү	(150,580)	(168,747)	-

Энэ үзүүлэлтээс харахад нийгмийн халамжийн тэтгэвэр, байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэл насны хүүхдийн тэтгэмжийн хэмжээ ядуурлын шугамаас дээгүүр буюу иргэний наад захын хэрэгцээг хангахуйц байна.

Асаргааны тэтгэмжийн тухайд 2023 оноос иргэний наад захын хэрэгцээг хангахуйц болсон байна. Байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш настай иргэний тэтгэмж, хүнс тэжээлийн дэмжлэгийн хэмжээ ядуурлын шугамтай харьцуулахад харьцангуй бага байна. Эдгээр үйлчилгээнд нарийвчилсан судалгаа, шинжилгээ хийж үр нөлөөг тооцох шаардлагатай байна.

Эх сурвалж: 1212.тп, Засгийн газрын тогтоолууд

Дээрх нийгмийн халамжийн үйлчилгээнүүдийн тарифын хэмжээг Үндэсний статистикийн хорооноос жил бүр баталдаг “Хүн амын амьжиргааны доод түвшин”-тэй харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 17: Нийгмийн халамжийн тарифын хэмжээ өрхийн амьжиргааны түвшний харьцаа /төгрөг/

Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023
Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээ	174,000	288,000	288,000	288,000	325,000
Хүн амын амьжиргааны түвшин /доод хэмжээ/	187,100	198,300	207,400	236,400	271,800
Зөрүү	(13,100)	89,700	80,600	51,600	53,200
Асаргааны тэтгэмж	76,000	84,500	84,500	84,500	275,000
Хүн амын амьжиргааны түвшин /доод хэмжээ/	187,100	198,300	207,400	236,400	271,800
Зөрүү	(111,100)	(113,800)	(122,900)	(151,900)	3,200
Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэл насны хүүхэд	174,000	288,000	288,000	288,000	325,000
Хүн амын амьжиргааны түвшин /доод хэмжээ/	187,100	198,300	207,400	236,400	271,800
Зөрүү	(13,100)	89,700	80,600	51,600	53,200
Байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш настай иргэн	20,000	20,000	20,000	20,000	20,000
Хүн амын амьжиргааны түвшин /доод хэмжээ/	187,100	198,300	207,400	236,400	271,800

²⁴ Ядуурлын шугам нь хүний эрүүл, идэвхтэй амьдралыг хангахуйц илчлэгтэй хоол, тэжээл, шаардлагатай бараа үйлчилгээний хэрэгцээг тусгасан хэрэглээний хамгийн бага зардал болно.

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

Зөрүү	(167,100)	(178,300)	(187,400)	(216,400)	(251,800)
Хүнс тэжээлийн дэмжлэг /том хүн/	16,000	16,000	16,000	16,000	16,000
Хүн амын амьжиргааны түвшин /доод хэмжээ/	187,100	198,300	207,400	236,400	271,800
Зөрүү	(171,100)	(182,300)	(191,400)	(220,400)	(255,800)

Эх сурвалж: Засгийн газрын тогтоолууд

3.31. Нийгмийн халамжийн тэтгэвэр, байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэл насны хүүхдийн тэтгэмжийн хэмжээ “Хүн амын амьжиргааны доод түвшин”-өөс дээгүүр байгаа нь иргэний наад захын хэрэгцээг хангахуйц байгааг дахин харуулж байна. Мөн асаргааны тэтгэмжийн 2023 оноос иргэний наад захын хэрэгцээг хангахуйц болсон байна.

3.32. Байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш настай иргэний тэтгэмж, хүнс тэжээлийн дэмжлэгийн хэмжээ мөн л харьцангуй бага байна.

3.33. Нийгмийн халамжийн чиглэлээр үзүүлж байгаа зарим үйлчилгээний хэмжээ болон олгож байгаа давтамжийг харьцуулахад дараах байдалтай байна.

Сар бүр – 200,000 ₮	Жилд 1 удаа – 140,000 ₮	Улиралд 1 удаа – 550,000 ₮
Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цолтон ахмад настан	Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, бүрэн хараагүй, бүрэн хэлгүй, дүлий, одой иргэн болон байнгын асаргаа шаардлагатай хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй хүнд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад	Гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж
Ахмад дайчин, дайнд оролцож яваад амь үрэгдсэн иргэний эхнэр /нөхөр/-т	Тэжээн тэтгэх хүүхэдгүй, эсхүл хууль ёсны тэжээн тэтгэгч нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх боломжгүй нь тогтоогдсон ахмад настан, хүндэт донор ахмад настанд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад	

3.34. Энэ үзүүлэлт нь зорилтот бүлэгт бага хөрөнгө зарцуулж байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл халамжийн сангийн хөрөнгийг зорилтод бүлгээс илүү нийтийг хамарсан шинжтэй үйлчилгээнд зарцуулж байна.

Нийгмийн халамжийн чиглэлээрх дээрх үйлчилгээнүүдийг үзүүлснээр ямар үр дүнд хүрсэн нь тодорхойгүй, цаашид юунд хүрэх, ядуурлыг бууруулахад нөлөөлж байгаа эсэх зэргээр үр нөлөөг тооцох, түүнийг үнэлж бодлогыг сайжруулах арга тогтолцоо дутагдалтай байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд нийгмийн халамжийн чиглэлээр тусгасан арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлж зорилго, зорилтдоо хүрэх, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг үнэлэх боломжтой байдлаар тодорхойлоогүй, мөн харилцан уялдаагүйгээс үйл ажиллагааны үр дүнд ямар эерэг өөрчлөлт бий болсныг хэмжиж үнэлэх боломжгүй байна.
2. Нийгмийн халамжийн тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиудын шинэчилсэн найруулга болон Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийн төслүүдийг Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт заасан хугацаанд батлагдаагүйгээс нийгмийн халамжийн чиглэлээр хэрэгжүүлэх бодлогын хүрээнд тодорхойлсон зарим арга хэмжээний хэрэгжилт хангагдахгүй байна.
3. Нийгмийн халамжийн тухай хуульд тусгасан “Нийгмийн халамж”-ийн нэр томъёог агуулгын хувьд олон улсын жишигт нийцүүлэн тодорхойлсон ч уг нэр томъёотой нийцээгүй, бүх нийтийг хамарсан шинжтэй үйлчилгээг хууль, тогтоомжоор бий болгон санхүүжилтийг халамжийн санд төвлөрүүлэн зарцуулж байгаагаас тус сангийн төсөв жилээс жилд нэмэгдсэн, нийгмийн халамж тэлсэн гэдэг ойлголт нийтэд бий болсон байна.
4. Бүх нийтийг хамарсан шинжтэй зарим үйлчилгээний тарифын хэмжээ, олгох давтамж нь зорилтод бүлгийнхээс харьцангуй өндөр үзүүлэлттэй, нөгөө талаар зорилтод бүлгийг бүрэн хамрагдуулаагүй байх магадлалтай зэрэг нь нийгмийн халамжийн талаар баримталж байгаа бодлогод нийцэхгүй байна.
5. Нийгмийн халамж чиглэлээр үзүүлж байгаа үйлчилгээг иргэдэд хүргэхэд анхаарч байгаагаас, нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлснээр хүрсэн үр дүн, эдийн засгийн үзүүлэлтүүдэд хэрхэн нөлөөлж байгаа зэргийг тооцсон судалгаа, дүн шинжилгээ хангалтгүй байна.
6. Нийгмийн халамжийн чиглэлээр үзүүлж байгаа 72 нэр төрлийн үйлчилгээнээс 67-г цахим хэлбэрт шилжүүлснээр иргэд e-mongolia, ehalamj.mn цахим хуудас, төрийн үйлчилгээний цахим “ТҮЦ” машин, ebarimt аппликэйшнийг ашиглан нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах хүсэлтээ гаргаж, үйлчлүүлэх боломжтой болсон ч цахим орчныг ашиглах, хэрэглэх чадвар, боломж дутагдалтайгаас цахим системийн ашиглалт хангалтгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Улсын Их Хуралд толилуулах нь:

1. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийгмийн халамжийн талаар тусгагдсан Нийгмийн халамжийн тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиудын шинэчилсэн найруулга болон Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийн төслүүдийг хэлэлцэн батлах,
2. Нийгмийн халамжийн тухай хуульд заасан “Нийгмийн халамж” гэсэн тодорхойлолттой нийцээгүй үйлчилгээнүүдийг Нийгмийн халамжийн тухай хууль болон бусад хууль тогтоомжоор бий болгон шаардлагатай хөрөнгийг халамжийн санд төвлөрүүлэн зарцуулах зохицуулалт бүхий хууль тогтоомжийн төслийг хэлэлцэн батлахгүй байх.

Үндэсний статистикийн хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд:

1. Нийгмийн халамжийн чиглэлээр үзүүлж байгаа үйлчилгээний нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг судалгаа, дүн шинжилгээнд үндэслэн тодорхойлж гарган, Үндэсний статистикийн хорооноос гаргадаг статистик өгөгдөлд багтаан, нийтэд ил тод, ойлгомжтой хэлбэрээр байршуулах ажлыг зохион байгуулах.

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад:

1. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийгмийн халамжийн талаар тусгагдсан (Нийгмийн халамжийн тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиудын шинэчилсэн найруулга болон Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийн төслүүдийг батлуулах) арга хэмжээний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах,
2. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт зорилго, зорилт, үйл ажиллагааг төлөвлөлтийн уялдааг хангасан, хэмжигдэхүйц, тодорхой хугацаанд хүрч болохуйц, бодитой, эерэг өөрчлөлт бий болгох байдлаар тодорхойлж, шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтод түвшнийг тодорхой тусгах арга хэмжээ авах.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдад:

1. “Нийгмийн халамж” гэсэн тодорхойлолттой нийцээгүй үйлчилгээнүүдийг нийгмийн халамжийн чиглэлээр үзүүлж байгаа үйлчилгээнээс зааглан тохиромжтой байдлаар ангилж шаардлагатай хөрөнгийг халамжийн сангаас тусад нь байршуулан зарцуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, холбогдох шийдвэрийг гаргуулах ажлыг зохион байгуулах,
2. Нийгмийн халамжийн чиглэлээр үзүүлж байгаа үйлчилгээнүүдийг зохицуулсан хууль, тогтоомжийн хоорондын харилцан уялдаа, давхардалд дүн шинжилгээ хийж холбогдох хууль, тогтоомжид тусгуулах ажлыг зохион байгуулах,
3. Халамжийн нэгдсэн систем www.ehalamj.mn болон бусад цахим хэрэгслийг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг эрчимжүүлж, цахим системийн ашиглалт хангалтгүй байгаа шалтгааныг тодорхойлон холбогдох арга хэмжээ авах.

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ирүүлсэн санал



**МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5, Утас: 26-15-53,
Факс: 32-86-34, Цахим шуудан: info@mlsp.gov.mn
Цахим хуудас: www.mlsp.gov.mn

2023.12.15 № 01/3296

тантай _____-ны № 01/2527-Т

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧИЙН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ц.НАРАНЧИМЭГ ТАНАА**

"Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө"-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад саналыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт .2. хуудастай.

Хүндэтгэсэн,



Х.БУЛГАНТУЯА

154231803

“Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө”-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд өгөх санал

Үндэсний аудитын газраас ирүүлсэн “Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө”-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад дараах саналтай байна. Үүнд:

1.Гарчиг.

“Нийгмийн халамжийн талаарх бодлого тодорхойгүйгээс баталсан төсвийн дийлэнхийг нийтийг хамарсан арга хэмжээнд зарцуулж байна” гэжээ.

Нийгмийн халамжийн тухай хууль 1995 онд батлагдсанаар нийгмийн халамжийн өнөөгийн бие даасан тогтолцооны суурь тавигдсан цагаас эхлэн өнөөгийн байдлаар Улсын Их Хурлаас баталсан Нийгмийн халамжийн тухай хууль, Ахмад настны тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай, Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хууль, Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай гэсэн нийгмийн халамжийн асуудлыг зохицуулсан 6 хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Эдгээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн холбогдох журам, дүрэм, удирдамж, мөн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээний зардлын хэмжээ зэргийг Засгийн газрын тогтоолоор болон нийгмийн халамжийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын баталсан нийт 50 гаруй тогтоол, тушаал шийдвэрээр нийгмийн халамжийн хуульд заасан бодлого арга хэмжээг чиг үүргийн салбарын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлж байна.

Мөн баталсан төсвийн дийлэнхийг нийтийг хамарсан арга хэмжээнд зарцуулж байна гэжээ. Нийтийг хамарсан арга хэмжээ гэж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хүрээнд ажилгүй иргэн, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор түр хугацаагаар ажиллуулж, орлогыг нэмэгдүүлэхийг хэлэх бөгөөд нийгмийн халамжийн хууль тогтоомжид энэ үг, хэллэг бүхий тэтгэмж, арга хэмжээ байхгүй.

Нийгмийн халамжийн үндсэн зорилго нь тухайн нийгмийн хамгийн эмзэг ядуу хэсгийг нийгмийн зүгээс ялгаварлал, гадуурхал, орлогын хомсдол зэрэг эрсдэлээс хамгаалах нийгмийн тэгш бус байдлыг бууруулах зорилгоор тэдэнд татварын орлогоос аливаа шимтгэлгүйгээр тэтгэвэр, тэтгэмж, дэмжлэг, үйлчилгээ үзүүлэхэд оршдог.

Харин сүүлийн жилүүдэд өрх, иргэний амьжиргаа харгалзахгүй, нийт хүн амд чиглэн олгосон нийтлэг мөнгөн тэтгэмж, тусламжийг халамжийн тогтолцоогоор

дамжуулан хэрэгжүүлсэн бөгөөд уг хөтөлбөрүүдийн зардал нийгмийн халамжийн зардал өсөхөд хамгийн их нөлөөлсөн. Бид энэ асуудалд дүн шинжилгээ хийж, нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн нэр төрөл, хамрах хүрээг оновчтой болгож зорилтот бүлэгт чиглүүлэх, эх, хүүхдэд үзүүлж байгаа тэтгэмж, урамшууллын бодлогыг нийгмийн халамжийн хууль тогтоомжоос ялгаж зааглах зорилгоор Нийгмийн халамжийн багц хуулийг шинэчлэх ажлыг хийж, Засгийн газар, Улсын Их Хурлын түвшинд хэлэлцүүлэхэд бэлэн болгоод байна.

Ийм учраас уг тайлангийн төслийн гарчгийг “Халамжийн сангийн батлагдсан төсвийн дийлэнх хувийг амьжиргаа харгалзахгүйгээр олгодог нийтлэг мөнгөн тэтгэмж эзэлж байна” гэж өөрчлөх саналтай байна.

2.Бүлэг 1.

1.3.Бодлогын баримт бичигт туссан зорилго, зорилтыг Хүснэгт 1-д харуулсан байна. Энэхүү хүснэгтэд тусгасан Монгол Улсын урт, богино хугацааны бодлогын баримт бичгийн зорилго, зорилт нь манай салбарын эрхлэх асуудлыг бүхэлд нь тусгасан бөгөөд харин уг зорилго, зорилтыг хэрэгжүүлэхээр нарийвчлан тусгасан халамжийн арга хэмжээг салбарын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ажиллаж байна.

Хүснэгт 1.

Бодлогын баримт бичиг	Зорилго	Зорилт	Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа
Алсын хараа-2050 2021-2030 онд "Нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчлэнэ" 2030-2050 онд "Амьдралын чанарыг сайжруулахуйц нийгмийн хамгааллын цогц үйлчилгээ үзүүлнэ"	Зорилго 3.Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин өрхийн орлогыг тогтвортой нэмэгдүүлж, идэвхтэй бүтээлч гэр бүлийг төлөвшүүлэн, хэрэгцээндээ нийцсэн байр сууц бүхий, хөрөнгө оруулалтын таатай орчин, нөхцөлд өрсөлдөхүйц бичил, жижиг, дунд бизнес эрхлэн өрх, гэр бүл, өөрийгөө тэтгэн амьдрах боломжтой, сэтгэл хангалуун амьдрах нөхцөлөөр тэтгэгдсэн дундаж давхаргыг бүрдүүлнэ.	Зорилт 2.3.Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжиж идэвхтэй, бүтээлч иргэн, гэр бүлийг төлөвшүүлнэ. Зорилт 3.1.Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ.	2.3.6.Өрхийн амьжиргааны түвшнийг тогтоох аргачлалыг боловсронгуй болгож, гэр бүлийн гишүүн бүрд үзүүлэх нийгмийн халамжийн тусламж, дэмжлэгийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. 2.3.7.Хүүхдийн тоо, наснаас хамааруулан хөнгөлөлт эдлүүлэх, хуримтлал бий болгох тогтолцоог бүрдүүлнэ. 2.5.22.Өрхийн хүнсний баталгаат байдал алдагдахаас зорилтот, эмзэг бүлгийн хүн амыг хамгаалах нийгмийн хамгааллын арга хэмжээг бэхжүүлнэ. 3.1.10.Нийгмийн халамжийн тусламж, дэмжлэг, үйлчилгээг зорилтот, эмзэг бүлгийн хэрэгцээнд нийцүүлж, амьжиргааг нь дээшлүүлэхэд чиглүүлнэ. 3.1.11.Нийгмийн халамж хүртэгсдийн мэдээллийн санг блокчейн технологид суурилан боловсронгуй болгож, нийгмийн хамгааллын үйл ажиллагааг сайжруулна. 3.1.12.Зорилтот бүлгийн өрхийг хөгжүүлэх, хамгаалах, тэдгээрийн амьжиргааг дээшлүүлэх орон нутгийн онцлогт нийцсэн шинэ төрлийн асрамжийн болон олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг нэвтэрүүлнэ.

<p>Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр</p>		<p>2.5.Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ.</p>	<p>2.5.5.Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг инфляц, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлнэ. 2.5.6."Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй болгоно. 2.5.7.Өрхийн амьжиргааны түвшинг тогтоох аргачлалыг боловсронгуй болгож, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг тууштай бууруулна. 2.5.12."Хуримтлалтай хүүхэд" арга хэмжээ хэрэгжүүлж, хүүхдийн мөнгийг тэдний хүнс, тэжээлийн хэрэгцээ, бие бялдар, хувь хүний хөгжил, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, хүүхдийн хуримтлал бий болгоход зарцуулах тогтолцоог бүрдүүлнэ.</p>
<p>Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл</p>	<p>Зорилго 3.Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, хүн амыг орон сууцаар хангах тогтолцоог бий болгож, дундаж давхаргын хүрээг тэлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ.</p>	<p>Зорилт 3.1.Нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчилнэ:</p>	<p>3.1.3.нийгмийн халамж зорилтод бүлэгт хүрч, халамжийн үйлчилгээ ил, тод нээлттэй, чирэгдэлгүй болно. 3.1.4.хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлнэ. 3.1.5.нийгмийн даатгалын сангийн болон халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг инфляцын түвшин болон хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулан нэмэгдүүлнэ.</p>

Тухайлбал, **Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн 2.3.6,** "Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.5.7-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд ХНХЯ-аас Өрхийн амьжиргааны түвшнийг тогтоох аргачлалыг боловсронгуй болгох, шинэчлэх ажлыг 2022 оноос эхлүүлсэн. Аргачлалыг боловсронгуй болгох энэ ажлын хүрээнд Ерөнхий сайдын 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 163 дугаар захирамжаар "Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа (ӨНЭЗС) болон өрх, иргэний талаарх төрд байгаа мэдээлэлд тулгуурлан өрх, хүн амын амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалыг боловсронгуй болгох санал боловсруулах" үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан ахалж, бүрэлдэхүүнд төрийн 15 байгууллагын төлөөлөл оролцон ажилласан. 2023 оны 1 дүгээр сарын 16-нд "Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох хосолмол аргачлал", "Захиргааны өгөгдөлд үндэслэн орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлал"-ыг ҮСХ-той хамтран баталсан. Өрхийн амьжиргаанд нөлөө үзүүлэхүйц

орлогыг орлуулан тооцож болох төрийн 5 байгууллагын 12 мэдээллийг ашиглаж өрхийн амьжиргааг үнэлэх боломжийг Монголд анх удаа бүрдүүлсэн. Аргачлалыг хүүхдийн мөнгийг 91 хувьд олгох, нийгмийн халамж шаардлагатай өрхийг тодорхойлох судалгааг зохион байгуулж, зорилтот бүлгийг тодорхойлоход ашигласан.

Түүнчлэн Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн 2.3.6, “Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.5.7, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл”-ийн 3.1.3, 3.1.4-д туссан зорилт, үйл ажиллагааг хүрээнд ХНХЯ-аас Нийгмийн халамжийн багц хуулийн шинэчлэлийг 2018 оноос боловсруулан Хууль тогтоомжийн хууль заасан үйл явцын дагуу хуулийн төслийн үзэл баримтлалыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон Хууль зүй, дотоод хэргийн сайдаар 2 удаа батлуулан, мөн дахин батлуулахаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 01/3416 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яаманд хүргүүлээд байна.

Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх хүртэлх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээг 2018 оноос эхлэн жил бүр авч хэрэгжүүлсэн. Энэ хугацаанд халамжийн тэтгэврийн хэмжээ халамж шаардлагатай иргэдийн наад захын хэрэгцээг хангахгүй, АДТ-нд хүрэхгүй, зөвхөн батлагдсан төсөвт багтаан нэмж байгаа талаар Сангийн яаманд тухай бүр танилцуулж ажилласны үр дүнд 2019 онд АДТ-ний хэмжээнд хүрч нэмэгдэж байсан. 2023 онд халамжийн тэтгэвэр 288 мянган төгрөг байсныг 325 мянган төгрөгт хүргэж нэмэгдүүлсэн нь 2023 оны АДТ-ний бүсүүдийн дунджаас 13.0 хувиар илүү байна.

Иймд тайлангийн төслийн 1.4-д заасан “...хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилго, зорилт харилцан уялдаагүй, ...бодлогын зорилтод нийгмийн халамжийн асуудлаар хангалттай тусгагдаагүй...” гэсэнтэй санал нийлэхгүй байна.

1.15.”...Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт батлагдсан хөтөлбөргүй байна...”

Энэ дүгнэлтийн ард нэмэлт тайлбар бичихгүй бол УИХ-аар батлуулахаар сүүлийн 2 жилийн хугацаанд хамтран ажилласан олон байгууллагын ажлыг үгүйсгэх талтай юм. Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх зорилгоор Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд дунд хугацааны буюу 10 жилийн хугацаатай салбарын дундын хамтын ажиллагааг тусгасан 7 хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр заасны нэг нь “Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр” юм.

Дээрх хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 57 дугаар захирамжаар, дэд ажлын хэсгийн Эдийн засгийн хөгжлийн сайдын 2022 оны А38 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан. Ажлын хэсгээс хөтөлбөрийн төслийг боловсруулан 2022 оны 7 сарын 6-ны өдөр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 7 дугаар сарын 8-ны өдөр УИХ-д өргөн барьсан. Гэвч Эдийн засгийн хөгжлийн сайдыг шинээр томилсонтой холбогдуулан уг төслийг УИХ-аас буцаан татаж авсан.

Уг төсөлд "Нийгмийн халамжийн үйлчилгээний хүртээмжийг оновчтой болгоно." Зорилтын хүрээнд "Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлгийн иргэдийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн шинэчилнэ.", "Нийгмийн халамжийн зорилтот бүлгийн иргэдийн хандлага, төлөвшлийг өөрчлөх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулан, бие даан амьдрах чадварыг дээшлүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ." гэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан.

1.23."Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын стратеги төлөвлөгөө нь бодлогыг зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн оновчтой, хэмжигдэхүйц, тодорхой хугацаанд хүрч болохуйц арга хэмжээ буюу үйл ажиллагааг тодорхойлоогүй байна." гэсэн дүгнэлтийг ямар үндэслэлээр өгч байгаа талаар тайлбар тусгах шаардлагатай.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2021-2024 оны стратегийн төлөвлөгөө"-нд халамжийн стратеги бодлогын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр 5 арга хэмжээг 4 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Тухайлбал, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг амьжиргааны доод түвшинтэй уялдуулан жил бүр нэмэгдүүлэх гэсэн үйл ажиллагааны хэрэгжүүлэхээр төлөвлөж, тэтгэврийн хэмжээг 15-аас багагүй хувиар нэмэгдүүлсэн байна гэсэн зорилтот түвшинг тодорхойлсон. 2023 онд халамжийн тэтгэврийн хэмжээг 325 мянган төгрөгт хүргэж нэмэгдүүлснээр 2021 онтой харьцуулахад 12.3 хувиар, асаргааны тэтгэмжийн хэмжээ /2020 оноос хойш нэмэгдээгүй байсан/ 275 мянган төгрөгт хүрч, 2022 оноос 2-3 дахин нэмэгдсэн. Мөн 2024 онд халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг 10 хувь нэмэгдүүлэхээр шаардагдах хөрөнгийг төсөвт тусгаад байна.

3.Бүлэг 2:

Бүлгийн нэр "...бүх нийтийг хамарсан үйл ажиллагаанд.." гэдгийг гарчгийн агуулгаар өөрчлөх

2.1. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөнд туссан нийгмийн халамжийн чиглэлийн зорилтын хэрэгжилтийн үнэлээг Хүснэгт 6-д нэгтгэн харуулсан байна. Эдгээрээс Зорилт:2.5.8, 2.5.9 нь халамжийн чиглэлийн үндсэн зорилтот хамаарахгүй, хүн амын бүлгүүдийн хөгжил оролцоо, хөдөлмөр эрхлэлтийн зорилт бөгөөд үүнтэй холбоотой уг тайлангийн 2.23-2.38, 2.41-2.45, 2.51-2.53, 2.68-2.69, 2.72-2.90 хүртэлх асуудал нь халамжийн үндсэн зорилгод хамаарахгүй юм.

2.66."Үүнээс үзэхэд дээрх аргачлал нь ... хамрагдах өрхийг бүрэн тодорхойлж чадаагүй байна." гэжээ.

Энэхүү аргачлалын дагуу бүрдүүлсэн төрийн мэдээллүүдийн бодит байдал зөрүүтэй байснаас өргөдөл, гомдол ихээр ирсэн, түүнээс өрхийн амьжиргааг үнэлэхэд аргачлалаас шалтгаалсан буруу тодорхойлсон асуудал байхгүй гэж яамны зүгээс үзэж байна.

2.96. Нийгмийн даатгал, нийгмийн халамжийн хүний нөөцийг чадавхжуулах сургалтын платформ, хөтөлбөрийг боловсруулахаар сонгон шалгарсан байгууллагатай хамтран ажиллаж, халамж, даатгалын салбар тус бүр 6 багц сэдэвт модуль хичээлийг бэлтгэснийг яам хүлээн авч онлайн сургалтын платформд байршуулахад бэлэн болгосон гэсэн тайлбар аудитын үйл явцын үед өгсөн болно.

4.Бүлэг:3. “..нийтийг хамарсан зүйл...” нэр өөрчлөх

3.9. "...хууль журмууд нь хоорондоо уялдаа муутай, хууль доторх зүйл, заалт нь логик уялдаагүй байна." гэжээ.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийн 4 дүгээр зүйлд Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүдэд олгож байгаа урамшууллыг "Эхийн алдар I, Эхийн алдар II одон"-оор шагнана гэж хуульчилсан. Харин уг хуулийн 4.2-т эдгээр одон авсан эхчүүдийг холбогдох хуульд заасны дагуу мөнгөн тусламж олгоно гэж заасан. Энэ заалтын дагуу Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5-д мөнгөн тусламж олгох зохицуулалтыг тусган хэрэгжүүлж байна. Өөрөөр хэлбэл Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд заасан урамшуулал гэдэг нь одонгоор шагнах асуудал харин Нийгмийн халамжийн тухай хуульд заасан зохицуулалт нь уг одонгоор шагнагдсан эхчүүдэд жилд нэг удаа мөнгөн тусламж олгох асуудлыг хуульчилсан юм. Ахмад настны тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль нь тухайн хүн амын бүлгийн онцлог хэрэгцээнд нийцсэн тусгайлсан тусламж, дэмжлэгийг төрөөс үзүүлж байгаа халамжийн тэтгэвэр, тэтгэмж дээр нэмж үзүүлэхийг зохицуулсан хууль юм. Харин төрийн зүгээс зайлшгүй дэмжлэг туслалцаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ядуурал, эмзэг байдал, эрсдэлт нөхцөлөөс хамгаалах зорилгоор олгож байгаа тэтгэвэр, тэтгэмжийг Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд зохицуулж хэрэгжүүлж байна.

3.15. "нийтийг хамарсан" гэдэг үгийг "амьжиргааны түвшинтэй уялдаагүй нийтлэг мөнгөн" гэж өөрчлөх.

3.19. Олон улсад нийгмийн халамжид хамрагдах зорилтот бүлгийг сонгох хэд хэдэн арга байдаг бөгөөд үүнээс хүн амын бүлгээс эмзэг бүлгийг сонгох /категорийн аргачлал/, газар зүйн байрлалаар, Орлогыг орлуулан тооцох арга гэх зэрэг аргыг манай улсад ашиглаж байна. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулийн хүрээнд нийгмийн халамжийн хамрах хүрээний дийлэнх хэсгийг хүн амын бүлэгт суурилан тодорхойлж байна.

Нийгмийн халамжийн тухай хуульд заасан нөхцөл, шалгуурыг хангасан иргэдэд халамжийн үйлчилгээ үзүүлдэг. Иймд Ахмад настны тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд заасан тэтгэмж, үйлчилгээнд тухайн бүлгийн иргэдийн амьжиргааны түвшинг харгалзахгүйгээр зөвхөн хуульд заасан шалгуурыг хангасан л бол тухайн арга хэмжээнд хамрагдах эрх нь үүсэж байдаг. Хүүхдийн мөнгөн тэтгэмж авдаг 1.2 сая хүүхдэд мөн амьжиргааны түвшин харгалзахгүй олгож байна.

Хүснэгт 12 дахь халамж авагч иргэдийн тоонд дээрх хуулиудын хүрээнд тэтгэмж, үзүүлдэг үйлчилгээнд хамрагдаж байгаа харьцангуй амьжиргааны түвшин

боломжийн иргэдийн тоо орсон байна. ҮСХ-ноос 2020 онд хийсэн “Ядуурлын дүр төрх” судалгаагаар 0-19 насны хүүхдийн ядуурлын түвшин 30.2-37.6 хувь байна гэсэн байна. Гэвч дээрх нийгмийн халамжид хамрагдагчид гэсэн энэ тоонд эдгээр хүүхдийн тоо ороогүй байна. Энэ тохиолдолд “Нийгмийн хүн амд халамж авагч иргэдийн эзлэх хувь ядуурлын хамралтын хүрээнээс бага байгаа нь нийгмийн халамж шаардлагатай зорилтот бүлэгт орхигдсон байх магадлалтай” гэсэн дүгнэлт оновчтой биш байна.

3.23. Нийгмийн халамжийн үйлчилгээ авч байгаа иргэдийн 88.0 хувь нь нийгмийн халамжийн байгууллагад очиж үйлчилгээ авсан байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас нийгмийн халамжийн 72 үйлчилгээнээс цахимжуулах шаардлагатай 64 үйлчилгээг бүрэн цахимжуулсан хэдий ч үйлчилгээ авч байгаа зорилтот бүлгийн иргэдийн дийлэнх нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өрх толгойлсон эцэг, эх, архины хамраалтай иргэд байдаг онцлогтой. Тэдгээр иргэдийн хувьд ухаалаг утас байхгүй, байсан ч ашиглаж мэдэхгүй, майл хаяг байдаггүй зэргээр цахим орчинд ажиллах ойлголт мэдлэг дутмаг учраас сум, хорооны ажилтанд хандаж байна. Түүнчлэн алслагдсан сум, орон нутгуудад интернет, дата хэрэглээ хязгаарлагдмал байгаа нь сум, хорооны нийгмийн ажилтанд хандах бас нэг шалтгаан болж байна.

Халамжийн үйлчилгээг цахимжуулах ажил 2020 оноос үе шаттайгаар хийгдсэн бөгөөд одоогийн байдлаар бүх үйлчилгээг цахимжуулсан боловч халамжийн үйлчилгээ авахад шаардлагатай байдаг эмч, эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт, Засаг даргын шийдвэр гэх зэргээр бусад төрийн байгууллагын үйлчилгээний цахимжилт хангалтгүйтэй холбоотой зарим бүрдүүлэх баримт бичгийг цаасаар цахим системд хавсаргаж бүрдүүлж байна.

3.26. “Ахмад настны асарч байгаа иргэд хөдөлмөр эрхэлж байгаа нь тус үйлчилгээг бүрэн үзүүлдэг гэдэгт эргэлзээ төрүүлэхүйц байна” гэжээ.

2008-2012 он хүртэл асаргааны тэтгэмж авдаг иргэн хөдөлмөр насных бол ажил хөдөлмөр эрхэлдэггүй байх гэсэн шалгуур нөхцөлтэй байсан. Тухайн үед тэтгэмжийн хэмжээ бага байсан тул иргэдээс санал, гомдол гарч байсан тул энэ шалгуурыг 2012 онд хуулиас хассан. Асаргааны тэтгэмжийн хэмжээ 2023 оны 7 сар хүртэлх хугацаанд маш бага буюу сард 84500 төгрөг байсан бөгөөд энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс даруй 6 дахин бага юм. Харин энэ оны 7 дугаар сараас энэ тэтгэмжийн хэмжээ 275000 төгрөг болж 2-3 дахин нэмэгдсэн ч ХХДХ-ээс 2 дахин бага хэвээр л байна. Тэгэхээр ийм хэмжээний тэтгэмж өгөөд хүнийг ажил хөдөлмөр эрхэлж болохгүй гэх нь зүйд нийцэхгүй бөгөөд харин ч хөдөлмөр эрхлэлтийн бодлого нь ажил хөдөлмөр эрхлэхэд хүндрэлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тохирсон ажил хөдөлмөр эрхэлж, амьжиргаа, орлогын нэмэгдүүлэхийг дэмжихэд чиглэж байна. Мөн орчин үед хөдөлмөрийн харилцааны хэв шинж өөрчлөгдөж байгаатай холбогдуулан хагас цагаар ажиллах, гэрээсээ цагийн ажил эрхлэх, алсын зайны ажил эрхлэх зэргээр уян хатан ажиллах нөхцөл боломжийг холбогдох хууль тогтоомжид бүрдүүлсэн.

3.28, 3.29. Нийгмийн халамж их байгаагаас ажил хийх сонирхол буурч байна гэсэн нийгэм, олон нийтийн шүүмжлэлийн дагуу судалгаа, шинжилгээ хийж үр дүнг гаргах зорилгоор тус яамнаас “Нийгмийн халамжийн бодлогын хөдөлмөр эрхлэлтэд үзүүлж буй нөлөө” сэдэвт захиалгат судалгааны ажлыг Удирдлагын академиар

хийлгэсэн. Энэ судалгааны үр дүнгээр халамж авдаг иргэд хөдөлмөр эрхлэх сонирхолгүй байна гэсэн олон нийтийн ойлголт хандлага нотлогдоогүй бөгөөд харин ч халамжийн мөнгөн тэтгэмж, тусламжийн хэмжээ бага тул иргэд албан ба албан бус салбарт хөдөлмөр эрхлэх байдал түгээмэл байдаг гэсэн судалгааны үр дүн гарсан.

3.33.Сар бүр 200 000 төгрөг олгож байгаа алдар цолтон ахмад настанд олгох нэмэгдлийн төслийг 2021 оноос халамжийн сангаас салгаж, салбарын сайд нарын төсөвт шилжүүлэн хэрэгжүүлдэг болсон.

5.Дүгнэлт, зөвлөмж

Нийгмийн халамжийн багц хуулийн шинэчлэлийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн нийгмийн халамжийн чиглэлийн зүйл, заалтуудыг өөрчилж шинэчилж байгаа бөгөөд хуулийн бусад агуулга буюу хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, хөгжил, оролцооны асуудал зохицуулалт , Саадгүй байдал, хүртээмжийн тухай хууль нь нийгмийн халамжийн харилцааг зохицуулах хуульд хамаарахгүй тул дүгнэлт хэсгээс хасах саналтай байна.

Дүгнэлт хэсгийн 3, 4 дэх хэсгийн нийтийг хамарсан шинжтэй үйлчилгээ" гэснийг гарчгийг агуулгаар өөрчлөх, тайлангийн төсөл дэх зарим үг хэллэг тухайлбал, "бүх нийтийг" эсхүл "нийтийг", мөн "нийтийг хамарсан зүйл", "нийтийг хамарсан үйл ажиллагаа" гэх зэргээр үгийн сонголтууд өөр байгааг анхаарах, эцэст нь тайлангийн төсөлд бодлогын баримт бичгүүдийн дүгнэлт бүлэг тус бүрд агуулгын хувьд давхардалтай байгааг анхаарах хэрэгтэй болно.

---000---

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас тайлангийн төсөлд ирүүлсэн санал



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗАР**

Чингисийн өргөн чөлөө,
20 дугаар хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17042
Утас/Факс: (976) 7013 6990.

Цахим шуудан: info@hudulmur-halamj.gov.mn,

Цахим хуудас: hudulmur-halamj.gov.mn

АДЛЗ-12-15 № 01/1523

тантай АДЛЗ-12-13 -ны № 01/2529 -т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

“Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө”-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд саналгүй болно.

Цаашид аудитын байгууллагаас гаргасан санал, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



ЗЭНХБОЛД

015512

Аудитын тайлангийн төсөлд санал авахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн боловч Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасан хугацаанд санал ирүүлээгүй тул мөн хуулийн 18.4-т заасныг үндэслэн саналгүйд тооцсон болно.

Төрөөс нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөө

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ирүүлсэн саналд дараах тайлбарыг өгч байна. Үүнд:

Санал 1	Саналыг авч ерөнхий дүгнэлтийг өөрчилсөн.
Санал 2	Нотлох баримтаар дэмжигдсэн тул саналыг хүлээн авах боломжгүй.
Санал 3	Нотлох баримтаар дэмжигдсэн тул саналыг хүлээн авах боломжгүй.
Санал 4	Зарим саналыг хүлээн авч тайланд өөрчлөлт оруулсан.
Санал 5	Зарим саналыг хүлээн авч тайланд өөрчлөлт оруулсан.